II. УСАН БОЛОРТ ҮҮСЭХ ЦЭГЭН ДЕФЕКТҮҮД

Усанболорыг γ -цацрагаар шарахад түүний өнгө өөрчлөгдөн утаат болор болдог нь цацраг бодисын харилцан үйлчлэлийн дүнд кристаллд олон янзын урвал процессууд явагдсаны дүнд үүсэх эффектүүдтэй холбоотой. Эдгээр эффектүүдийн нэг нь цэгэн дефект юм [1]. Цэгэн дефектүүд нь үүсгэж байгаа шалтгаанаасаа хамаараад олон янз байх боломжтой. Цэгэн дефектүүд нь эгэл торд атомын шилжилт үүсэх, атомуудын холбоос тасрах болон гадны өөр хольцын атомууд орж ирснээс шалтгаалан атомын бүтцэд гажилт үүсгэдэг [2]. Цэгэн дефектүүдийг тэдгээрийн

*Electronic address: tuvjargal@num.edu.mn

электроны конфигурацид нь үндэслэн хослоогүй электронуудаас тогтож байвал *парасоронзон* дефект, бусад тохиолдлуудыг нь *диасоронзон* дефект гэж ангилдаг. Парасоронзон дефект нь хослоогүй электронуудын тэг биш соронзон моментуудаас шалтгаалан соронзон резонансын шингээлт буюу Электроны парасоронзон резонанс (ЭПР) өгдөг.

Цэгэн дефектүүдийн жишээ гэвэл: нүх үүсэх (торын зангилаа цэгт атом алга болох), завсрын (торын зангилаа биш завсарт атом байрлах) болон валентийн ($\text{Si} - \text{O}$ холбоос эвдрэх) дефектүүд болно. Усанболорт үүсэх цэгэн дефектүүд нь дараахи хэлбэрүүдтэй байна. Үүнд: нейтрал хүчилтөрөгчийн нүх [3]: $\text{O} \equiv \text{Si} - \text{Si} \equiv \text{O}$, перокси гүүрэн: $\text{O} \equiv \text{Si} - \text{O} - \text{O} - \text{Si} \equiv \text{O}$, гүүрэн биш хүчилтөрөгчит: $\text{O} \equiv \text{Si} - \text{O}^\bullet$, гурван координаттай цахиуран: $\text{O} \equiv \text{Si}^\bullet$ (ихэвчлэн E' төв гэж нэрлэдэг.), хоёрлосон координаттай цахиуран: $\text{O} = \text{Si}^{\bullet\bullet}$. Эдгээрийн дефектүүдийн дүрслэлийг зураг.2-т үзүүлэв. Эдгээр дефектүүд



Зураг 2: Усанболорт (SiO_2)-т үүсэх зарим цэгэн дефектүүд: Энд сумаар электроны спинийг, $-$, $=$, $\equiv$ Si -той холбогдох O -ийн холбоосыг, $\bullet$ -ээр холбоос нь эвдэрсэн хослоогүй электроныг, $\bullet\bullet$ -ээр холбоост ороогүй электроныг хосыг дүрслэн үзүүлэв.

нь электрон эсвэл нүхийг барих зарим энергийн төлвүүдийг үүсгэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Цэгэн дефектийн үндсэн болон өдөөгдсөн электроны төлвүүд нь усанболорын хаалттай бүсийн энергиэс бага энергийн завсартай байна. Иймээс $\text{O} \equiv \text{Si} - \text{O}^\bullet$ болон $\text{O} \equiv \text{Si}^\bullet$ дефектүүдийг валентийн болон дамжуулаллын бүсийн хооронд байрлах төлвүүдтэй холбоотой үүсдэг тул

эвдэрсэн холбоосын төлөв гэж нэрлэдэг. Цахилгаан соронзон орноор үүсгэгдэж байгаа электроны төлвийн шилжилттэй холбоотой дефектүүдтэй холбоотойгоор материалын шингээлтийн болон цацаргалтын бүсийн энергийн завсар өөрчлөгдөх бөгөөд энэ нь тухайн материалын тунгалаг чанар өөрчлөгдөх шалтгаан болдог. Мөн эдгээр дефект нь электрон болон нүхийг барих учраас материалын тусгаарлагч чанарыг ч өөрчилдөг. Түүнчлэн парасоронзон дефект нь маш бага ($\sim 10\mu\text{eV}$) засвар бүхий электроны төлвүүдийн дахин хуваарилалт болон соронзон орны нөлөөгөөр материалын соронзон шинж чанар мөн өөрчлөгддөг. Парасоронзон дефектүүдээс шалтгаалан материалын оптик шингээлт, цацаргалтын бүс өөрчлөгдөх бөгөөд электроны парасоронзон резонансын үзэгдэл ажиглагдах шалтгаан болно. $\text{O} \equiv \text{Si} - \text{O}^\bullet$ болон $\text{O} \equiv \text{Si}^\bullet$ хэлбэрийн дефектүүд нь ^{29}Si болон ^{17}O изотопор баялаг болсон дээжүүдэд ажиглагдана [4].

γ цацрагийн үйлчлэлээр цэгэн дефект үүсэх процесс

Материалыг халаах, хөргөх болон механик үйлчлэлд оруулах зэрэг янз бүрийн аргаар цэгэн дефектүүд үүсгэж болдог. Үүний нэг болох өндөр энерги бүхий цацрагийн үйлчлэлээр цэгэн дефект үүсэх механизмийг авч үзье.

Усанболорт цэгэн дефект үүсгэх хамгийн өргөн хэрэглэгддэг механизм нь бөөмсийн (электрон, нейтрон, ион гэх мэт) багц цацраг эсвэл иончлогч цацраг (UV, X-ray, γ -цацраг гэх мэт)-аар шарах зэрэг орно. Материалыг γ -цацрагаар шарсаны дүнд түүний энергиэс хамааран олон процесс явагдах боломжтой. Бага энерги бүхий цацрагийн үйлчлэлээр зонхилон Компторны сарнил тохиолдох бөгөөд үүний дүнд дараахи хоёр механизм явагддаг. Үүнд:

- Knock-on процесс: энэ нь цацаргалтын кинетик энергиэ шууд солилцсоны дүнд атом шилжих процесс
- Radiolysis процесс: энэ нь электроныг өдөөх эсвэл иончилсоны дүнд атом байрлал шилжих болон холбоос тасрах процесс

Цацрагийн үйлчлэлээр нийт кинетик энерги хадгалагдах харимхай болон цацаргалтын кинетик энергийнхээ тодорхой хэсгийг электроны шилжилт хэлбэрээр алдах харимхай биш гэсэн хоёр төрлийн knock-on процессын явагдах [5]. Атомын шилжилтийн дүнд дефект үүсэхийн тулд үйлчилж буй цацраг бай атомын холбоосыг таслахын тулд хангалттай энергитэй байх хэрэгтэй. Атомыг шилжүүлэхэд шаардагдах

энергийг шилжилтийн энерги T_d гэж нэрлэдэг. Энэ нь Si-ийн хувьд $T_d^{Si} \cong 20\text{eV}$, O-ийн хувьд $T_d^O \cong 10\text{eV}$ байх бол Si – O холбоосын энерги $\sim 5\text{eV}$ орчим байдаг [6]. Хурдан нейтрон, дулааны нейтрон, их энергитэй электрон болон γ цацрагаар шарах үед "knock-on" мөргөлдөөний дүнд атомын шилжилт үүсдэг. Тухайлбал, усанболорыг хурдан нейтрон ($E > 0.1\text{MeV}$)-оор шарах үед атомын шилжилтийн процессийн дүнд $\sim 2 \cdot 10^{19}$ спин/см³ парасоронзон төв (нийт хүчилтөрөгчийн атомын 0.05%) үүсдэг байна [7].

Radiolytic процессын үед эхлээд электроны төлвийг өөрчлөх боловч энэ нь тогтворгүй ион эсвэл атомын дефект хэлбэрээр тогтоно. Эдгээр өдөөгдсөн электронууд нь электроны тогтвортой төлөв хүртэл бусад процессуудын шалтгаан болно. Электроны өдөөлт, иончлол болон холбоос эвдрэх энэ процесс (radiolytic) электрон болон γ цацрагийн үйлчлэлийн үед knock-on процессоосоо хэд дахин их тохиолддог. Цацрагийн үйлчлэлээр үүсэх эффект нь ихэвчлэн материалд шингээгдсэн энергийн хэмжээгээр тодорхойлогддог. Энэ энергийг тодорхойлохын тулд эхлээд сарнилын дифференциал огтлол $\sigma_E(\Theta, T)$ -ийг авч үздэг. Үл хамаарах мөргөлдөөний тохиолдол (knock-on, radiolytic)-уудын хувьд $\sigma_E(\Theta, T)$ нь тусаж байгаа E энерги бүхий бөөмсийн T -ээс $T + dT$ энергийн завсар болон θ -ээс $\theta + d\theta$ хазайлтын өнцгийн завсар дахь магадлалын нягт юм. Дифференциал огтлолоос бай материалын нэгж уртад шилжүүлэх энерги $(-dE/dx)$ -ийг олох боломжтой. Мөргөлдөөний туршид дээж материалд шилжих энерги T бол дээжний δr завсарт шилжүүлэх дундаж энерги нь:

$$\langle T \rangle = N \delta r \int_0^\pi \int_{T_{\min}}^{T_{\max}} T \sigma_E(\Theta, T) d\theta dT. \quad (1)$$

Энд N нь нэгж эзэлхүүн дэх сарнилын төвийн тоо, $T_{\max}, T_{\min}$ нь шилжүүлэх энергийн хамгийн их болон бага утга, δr нь нэг мөргөлдөөний хувь дахь хангалттай бага хэмжээс. Түүнчлэн δr завсарт алдсан дундаж энерги $\langle \Delta E_1 \rangle$ нь дээж материалын нэгж уртад шилжүүлэх энергитэй тэнцүү:

$$\left(-\frac{dE}{dx} \right) = -\frac{\langle \Delta E_1 \rangle}{\delta r} = N \int_0^\pi \int_{T_{\min}}^{T_{\max}} T \sigma_E(\Theta, T) d\theta dT. \quad (2)$$

Алдсан энергийг шингээгдсэн дозе гэж нэрлэдэг бөгөөд дээжний зузаан x бол энэ дараахи хэлбэртэй байна.

$$D = \frac{\phi \Delta t}{x} \int_0^x \left| \frac{dE}{dx} \right| dx, \quad (3)$$

энд $\phi \Delta t$ нь тусч байгаа бөөмсийн урсгал.

Radiolytic процессын үед үүсдэг түгээмэл дефектүүдийн нэг бол парасоронзон төв юм. Энэ нь хослоогүй электронтой молекулын нэгж бөгөөд түүний шинж чанарыг соронзон орон ашиглан ЭПР спектроскопи ашиглан судладаг [8]. Парасоронзон төвүүд нь photolysis, thermolysis, radiolysis, electrolysis болон бусад химийн урвалын дүнд үүсдэг. Хүчилтөрөгч нь парасоронзон төвүүд үүсгэхэд маш идэвхитэй оролцдог. Хамгийн түгээмэл парасоронзон төвүүдэд чөлөөт радикалууд, бирадикалууд, парасоронзон металл ион, гурвалсан үндсэн төлөв бүхий хүчилтөрөгчийн O_2 молекул болон парасоронзон дамжуулаллын төрлүүд орно. Парасоронзон төвүүд нь өөр өөр спин болон тогтворжилттой байдаг. Парасоронзон төвүүдийн соронзон момент нь тэдгээрийн спинээс хамаарах ба гадны соронзон орны нөлөөгөөр тэдгээр соронзон момент нь цэгцэрсний дүнд ЭПР дохио бүртгэгддэг.

Материалд үүсэж байгаа цэгэн дефектүүдийн үүсэх процессийг танин мэдэхийн тулд дулааны боловсруулалтын аргыг өргөн хэрэглэдэг. Цацрагийн үйлчлэлээр үүссэн зарим дефектүүд нь материалын температурыг нэмэгдүүлэхэд алга болдог. Ерөнхийдөө цацрагийн үйлчлэлд орсон материалыг халаахад тодорхой температурт тодорхой дефектүүд арилдаг байна. Түүнчлэн энэ аргаар дефектийн бүтэцтэй холбоотой молекулын холбоосын хүч, дефектийн потенциал нүхний гүн зэрэг чухал мэдээлэлүүдийг олох боломжтой. Мөн дулааны боловсруулалтын аргаар тодорхой үзэгдлүүдийн хамаарал зүй тогтолыг судлах боломжтой. Тухайлбал, оптик шингээлтийн спектроскопи болон ЭПР спектроскопи арга ашиглан тодорхой дулааны боловсруулалтын нөхцөл дор материалын макроскопик шинж чанарыг судлах боломжтой.

Бид энэ ажлын хүрээнд монгол орны байгалийн дээж болох кристалл усанболор дээжийн хувьд өндөр энерги бүхий γ цацрагаар шарсан болон шарсны дараа дулааны боловсруулалтанд оруулсан дээжүүдэд үүсэх парасоронзон дефектүүдийн концентрациас нь хамааруулан ЭПР спектроскопийн аргаар судлах зорилготой.

III. ЭЛЕКТРОНЫ ПАРАСОРОНЗОН РЕЗОНАНСЫН ЭФФЕКТ

ЭПР нь соронзон орон дахь дээжинд микродолигоноор илрүүлсэн парасоронзон дефект ажиглагдах эффект юм [8]. Соронзон орны нөлөөгөөр энергийн түвшинд Зееманы салалт болдог. Соронзон оронд хослоогүй


электронуудын энергийн түвшнүүд салсны дараа тэдгээрийн соронзон моментууд нь янз бүрийн чиглэлтэй байдаг. Ө.х соронзон индукцийн вектор B -тэй параллель болон параллель биш янз бүр байна. Соронзон орон дахь соронзон момент болон спины соронзон квант тоо M_s нь хоёулаа $2S + 1$ утгатай байна. Соронзон оронд M_s спины соронзон квант тоо бүхий хослоогүй электроны энергийн түвшин $2S \pm 1$ түвшнүүдэд салаалдаг. Хослоогүй электрон микродолгионоор өдөөгддөг ба энд микродолгионы энерги болон давтамж нь дараахи илэрхийлэлийн дагуу өгөгдсөн резонансын нөхцөл биелэх тохиодолд их энергитэй түвшин рүүгээ шилжинэ:

$$h\nu = E_2 - E_1 = g\mu_B B_r, \quad (4)$$

энд h нь Планкийн тогтмол, ν нь микродолгионы давтамж, g нь спектроскопик фактор, μ_B нь Борын магнитон, B_r нь резонансын соронзон орны индукцийн вектор, E_2 нь хослоогүй электронуудын өдөөгдсөн төлөвийн энерги, E_1 нь хослоогүй электронуудын үндсэн төлөвийн энерги. B индукцийн вектортой соронзон орон дэх M_s соронзон спины квант тоо бүхий хослоогүй электроны энерги дараахи хэлбэртэй байна.

$$E(M_s) = M_s g \mu_B B_r. \quad (5)$$

ЭПР эффектгүйг бас электроны спин резонанс (ЭСР) гэж нэрлэдэг. Учир нь парасоронзон материал дэх хослоогүй электронууд нь хослоогүй спинтэй байдаг. ЭПР (ЭСР) спектроскопийн үндэс нь дээр тодорхойлсон эффект болдог бөгөөд энэ нь парасоронзон дефектүүдийг судлах туршилтын аргын үндэс болдог. Парасоронзон материалуудыг соронзон оронд оруулахад тэгш, 4 резонансын нөхцлийг хангах энерги бүхий микродолгионыг шингээдэг. ЭПР спектроскопийг ашиглан шингээлт болон нэгдүгээр эрэмбийн уламжлалын шугамд анализ хийх болно. Нэгдүгээр эрэмбийн уламжлалын муруйн комплекс парасоронзон төвүүдийн систем бүхий дээжүүдийн хувьд маш чухал байдаг. Олон компонент бүхий ЭПР спектрын компонентүүдийн шугамын нарийвчлал шингээлтийн муруйн хувьд нэгдүгээр эрэмбийн уламжлалаар хялбар ялгагдана. Чөлөөт радикал бүхий парасоронзон материалын хувьд соронзон орны нөлөөгөөр $S = 1/2$ спин бүхий энергийн түвшинд Зееманы салалт болж хоёр түвшинтэй болно. Соронзон орон дэх чөлөөт радикалуудын Зееманы салалтыг зураг.3-т үзүүлэв. Зураг.3-т соронзон оронтой болон оронгүй үе дахь чөлөөт радикалуудын хослоогүй электроны энергийн түвшин болон микродолгионы шингээлт болон нэгдүгээр эрэмбийн уламжлалын муруй зэргийг үзүүлэв.



Зураг 3: $S = 1/2$ спинтэй чөлөөт радикалын соронзон орон дахь Зееманы эффект. Энд шингээлт болон эхний ЭПР шингээлтийн муруйг үзүүлэв. B -соронзон орны индукцийн вектор, B_r -соронзон резонансын индукци, h - Планкийн тогтмол, ν - микродолгионы давтамж, g - спектроскопик фактор, μ_B - Борын магнитон, $h\nu = g\mu_B B_r$ - резонансын томъёо.

IV. ТУРШИЛТ

Судалгааны дээж болох цэвэр усанболор (SiO_2)-ийг тэнцүү хэсгүүдэд хуваагаад электроны цикл хурдасгуур Микротрон МТ-22 (МУИС-ийн ЦФСТ, Цацрагийн урсгалын нягт $\Phi_\gamma \simeq (7.2 \cdot 10^{11} - 1.2 \cdot 10^{11}) \text{ } \gamma/\text{см}^2 \cdot \text{сек} \cdot \text{мкА}$, $I_e = 9 \text{ мкА}$) цацраг идэвхит үүсгүүр дээр $E_e = 22 \text{ МэВ}$ хүртлэх энерги бүхий нил спектртэй саатлын гамма цацрагаар нэг цаг шарж бэлтгэнэ. Дээжны шараагүй хэсгийг шарсан дээжтэй харьцуулан судлахад ашиглах болно.


Дулааны боловсруулалт: Цацрагаар шарж бэлдсэн дээжний тодорхой хэсгүүдийг шатаах зууханд (МУИС-ийн орчны шинжилгээний лаборатори) 100°C болон 200°C температурт 24 цаг халааж дулааны боловсруулалтанд оруулан туршсан.

СЭПР2 (МУИС-ийн ЭПР спектроскопийн лаборатори) электроны парасоронзон резонансийн спектрометр ашиглан гамма

цацрагаар шарсан болон шараагүй, дулааны боловсруулалтанд оруулсан усанболорын дээжийн ЭПР спектрийг $\Delta H = 500$ Гс, $H_r = 1200$ Гс, $\tau = 0.3$ с, $\Delta t = 30$ с-ийн горимд хэмжсэн.


V. ҮР ДҮН

Сонгож авсан усанболор (SiO_2)-ын дээжээ γ - цацрагаар шарсны дараа дээж гүн хар өнгөтэй болж утаатболор болсон болон 200°C температурт 24 цаг халааж дулааны боловсруулалтанд оруулсаны дараа буцаад тунгалагжиж байгааг зураг.4-т үзүүлэв. Гамма цацрагийн үйлчлэлээр



Зураг 4: Усанболор (SiO_2): a) байгалийн цэвэр дээж, b) γ цацрагаар шарсан дээж (Утаат болор), c) γ цацрагаар шарж утаат болор болгосон дээжийг 200°C -т 24 цаг халаасны дараахи хагас тунгалаг усанболор.

усанболор дээжинд knock-on болон radiolysis процесс явагдсаны үр дүнд маш олон тооны янз бүрийн дефектүүд үүсэж байгаагийн нэг нь парасоронзон төвүүд юм. Үүнийг бид ЭПР спектроскопи ашиглан хэмжсэнийг зураг.5-т үзүүлэв. Энд нунтаг дээжийг хэмжсэн учраас гадны соронзон оронтой харьцуулахад гажиг нь ямарваа нэг зонхилсон зүгшрэл үүсгэснээс болж илрэх резонансын хэсгүүд бүртгэгдэхгүй гэсэн үг юм. Нунтаг дээжинд үүссэн дефект нь бүх чиглэлд ижил магадлалтайгаар байрлах тул бүртгэгдэж буй спектр нь бүх дефектийн нийлбэр хувь нэмрийг үзүүлнэ. ЭПР спектрт өгч байгаа 1200 Гс орны үед үүсэж байгаа резонанс нь гамма цацрагаар шарсны дүнд үүсэж байгаа парасоронзон дефектүүдэд харгалзана. Эндээс бид γ цацрагаар шарсан болон дулааны



Зураг 5: Цэвэр, γ цацрагаар шарсан болон 200°C -т 24 цаг халаасан Усанболор (SiO_2) дээжийн ЭПР спектр.

боловсруулалтанд оруулсны дараа усанболор дээжинд үүсэж байгаа өнгөний хувиралыг тайлбарлах зорилгоор тухайн дээжинд үүсэж байгаа парасоронзон дефектийн концентрацийг нүүрсний эталон дээжний ЭПР спектртэй харьцуулах замаар үнэлсэн. γ цацрагаар шарсан усанболор дээжин дахь парасоронзон дефектийн концентарци $N_{ir} = 6.6 \cdot 10^{18}$ (спин/грамм) байгаа бол дулааны боловсруулалтанд оруулсны дараа $N_{ht} = 5.9 \cdot 10^{18}$ (спин/грамм) болж цөөрсөн байна. Эндээс γ цацрагийн үйлчлэлээр Усанболорт парасоронзон дефект үүсэх бөгөөд энэ дефект нь дулааны үйлчлэлээр эдгэж байгаа нь харагдаж байна.

VI. ДҮГНЭЛТ

Байгалийн хагас үнэт чулуу болох усанболор (SiO_2)-ийг γ цацрагаар үйлчлэхэд түүний өнгө өөрчлөгдөн утаат болор болж байна. γ цацраг бодистой харилцан үйлчилсэний дүнд цацрагийн энергиэс хамааран комптоны сарнил, фото-цахилгаан эффект, электрон позитроны хос үүсэх зэрэг процесс явагдсаны дүнд кристаллд олон янзын дефект үүссэний улмаас түүний өнгө өөрчлөгддөг. Бид өмнө рентген дифракцийн аргаар усанболорт γ цацрагийн үйлчлэлээр атомын шилжилт хийж, кристалл гажиж байгааг тогтоосон[9]. Бид энэ ажлаар γ цацрагийн үйлчлэлээр усанболорт парасоронзон төвүүд үүсэж байгааг ЭПР спектроскопийн аргаар судлаж тогтоов. Судалгааны үр дүнгээс үзэхэд гамма цацрагаар шарсны үр дүнд олон тооны парасоронзон төвүүд үүсч байгаагаас гадна дулааны боловсруулалтын дүнд эдгээр төвүүд эдгэрч байгааг үзүүлэв. Цаашид ЭПР

спектроскопийн аргатай оптик шингээлтийн спектроскопийн аргыг хослуулан янз бүрийн горимд дулааны боловсруулалтанд оруулах замаар нарийвчлан судлах хэрэгтэй.

санхүүжүүлсэн ШУТС болон БСШУЯ-нд талархал илэрхийлье.

Талархал

Энэхүү ажлыг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлж суурь судалгааны SST_018/2015 төслийг

-
- [1] Ed. Catlow R., *"Defects and disorder in crystalline and amorphous solids"* Kluwer Academic Publishers (1994)
 - [2] Kittel C., *"Introduction to Solid State Physics"* John Wiley and Sons (1971).
 - [3] Elliott S.R., *"Physics of amorphous materials"* Longman, London, 2 Ed. (1990).
 - [4] Griscom D.L., J. Ceramic Society of Japan 99 (1991) 899
 - [5] Eds. Devine R.A.B, Duraud J.P. and Dooryh  e E., *"Structure and imperfections in amorphous and crystalline silicon dioxide"* John Wiley and Sons (2000).
 - [6] Gupta R.P., Phys. Rev.B 32 (1985) 8278.
 - [7] Chan S.L., Gladden L.F. and Elliott S.R., J. Non-Cryst. Sol. 106 (1988) 413.
 - [8] Wertz JE, Bolton JR., *"Electron Spin Resonance: Elementary Theory and Practical Applications"* London: Chapman and Hall; 1986.
 - [9] Ч.Цэцэнжаргал, Т.Очирхуяг, Н.Т  вжаргал, Д.Баатарх  у, Л.Ням-Очир. *"Гамма цацрагийн   ймчл  лээр усанболор (SiO_2)-т   гсэх эффект  ийн судалгаа"* МУИС-ийн эрд  м шинжилг  эний бичиг 438, ФИЗИК с  тг  л (20), 2015, 63
 - [10] Л.Баяржаргал, Д.Сангаа, Д.Баатарх  у, МУИС-ийн   ШБ №179(10), 2003, 99-105
 - [11] Б.Бумаа, А.Бадмаараг, Д.Баатарх  у, Д.Сангаа., ШУА-ийн ФТХ-ийн   ШБ №36, 2008.

Хөө, Үнсэнд Хийсэн Рентген Дифракцийн Фазын Судалгаа

Ж. Ванчинхүү¹, Э. Баянжаргал², Ж. Даваасамбуу¹

¹Физикийн тэнхим, ШУС, МУИС

²Аналитик лаборатори, Материал судлалын салбар, ФТХ-ШУА

Нүүрсний шаталтаас ялгарах хөө, үнсийг инерцийн болон конвекцийн суулт ашиглан цуглуулж гарган авсан дээжүүдэд рентген дифракцийн судалгааны арга ашиглан бүтцийн анализ хийсний дүнд хөө, үнсний доторхи талст болон аморф фазын агуулгыг тогтоов. Хөөнд талст тогтоцтой нүүрстөрөгчийн графит бүтцээс гадна шатаасан нүүрсэнд агуулагдах элементүүд шаталтын явцад бий болсон нэгдэл хэлбэрээр талст бүтэц үүсгэн агуулагдаж байдаг байна.

PACS number: 52.80.Hc, 47.57.-s

I. Оршил

Шаталтын бүтээгдэхүүний талаар хийсэн судалгааны олон эх үүсвэрт хөө гэсэн нэрнээс гадна хар нүүрстөрөгч (black carbon), анхдагч нүүрстөрөгч (elemental carbon) гэсэн нэрээр орсон байдаг. Хөөний эдгээр нэр томъёо хэрэглэгддэг шалтгаан нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нэр томъёо дутмаг байдаг оршино. Эдгээр нэр томъёог өгөхдөө судалж, ажиглаж байгаа аргатайгаа уялдуулсан байдаг. Тухайлбал хар нүүрстөрөгч нэр томъёог түүнийг тодорхойлоход оптик арга ашиглаж байгаа тохиолдолд гэрэл шингээгч гэдэг утгаар нь нэрлэжээ. Харин анхдагч нүүрстөрөгч нэр томъёог химийн болон дулааны тодорхойлолттой уялдуулан хэрэглэ-дэг. Ер нь эдгээр нэр томъёогоор тэмдэглэгдэх дисперслэгдсэн жижиг хэсэг болох тэрхүү «зүйл» нь хөөний үндсэн бүрэлдэхүүн болдог гэдгийг бүх судалгаа хүлээн зөвшөөрдөг. Өөрөөр хэлбэл хөөг эдгээр нэрээр нэрлэгдэх олон тооны дисперсэт буюу жижиг хэсгүүдээс тогтоно гэж үздэг [1]. Шаталтын зайлшгүй нэг үр дагавар буюу дагалдах үзэгдэл бол нүүрстөрөгч агуулсан бөөмцөр үүсэх үзэгдэл юм. Мод, нүүрсний шаталтад ажиглагддаг улаан шаравтар гэрэл нь дөлөн дэх хөөний дулаан цацаргалтаар бий болдог бөгөөд энэ нь хөө шаталтын захын хэсэгт үүсдгийн нэг том баталгаа болж байдаг.

Хөө үүсэх анхдагч үр хөврөл нь полициклийн үнэрт нүүрс устөрөгчийн нэгдэл байдаг. Хөө нь найрлагын хувьд нэгэн төрлийн биш бөгөөд түүний ихэнх хэсэг нь нүүрстөрөгч байх ба 10 хүртэл хувийг устөрөгч эзэлж байдаг байна. Хөөнд байгаа C/H буюу нүүрстөрөгч ба устөрөгчийн атомын харьцаа 1-8 байна. Энэ харьцаа хөөний бөөмцрийн диаметр D өсөхөд шугаман хуулиар өсдөг. Энэ нь хөөн дэх нүүрстөрөгчийн атомын тоо D^3 -д, харин устөрөгчийн атомын тоо D^2 -д пропорциональ

байхыг үзүүлж байгаа бөгөөд эндээс устөрөгч зөвхөн хөөний гадаргуу дээр суудаг гэсэн дүгнэлт гардаг [2]. Хөөний дундаж нягт 2 г/см^3 байна. Хөөний ширхэгүүдийн хэмжээ бага боловч хувийн гадаргуугийн хэмжээ их байдаг учраас өөр агаар бохирдуулагчыг сайн шингээдэг [4]. Хөөнд хийсэн зарим судалгааны ажилд түүнд агуулагдаж байгаа бодисууд зөвхөн аморф төдийгүй талст фаз хэлбэртэйгээр оршдог тухай дурдсан байдаг [3-4]. Энэ ажилд бид хөөн дэх талст хэлбэртэйгээр оршин байгаа эрдсүүд болон аморф фазын хэмжээг тогтоох асуудлыг авч үзлээ.

II. Дээжийг авсан нөхцөл

Гэрийн зуухны янданд инерциаль суулт болон конденсацын процессийн үр дүнд хөө тортог тогтож суудаг. Янданд тогтох хөөний хэмжээ түлшний төрөл, химийн найрлага болон галлалт ба цаг уур, уур амьсгалын хүчин зүйлүүдээс шалтгаалж байдаг. Хөөг их хэмжээгээр хуримтлуулж авахын тулд удаан хугацааны туршид шатаалт явуулж их хэмжээний түлш зарцуулах шаардлагатай. Энэ ажилд судалсан хөө нь Улаанбаатар хот дахь Монгол гэрүүдийн халаалт, ахуйн хэрэглээнд өргөн хэрэглэгдэж байгаа ХАС зууханд дан Налайхын нүүрсийг шатаахад янданд тогтсон хөө юм.

III. Хөөг бий болгосон орчин, нөхцөл

Галлалтын давтамж: Хоногт 4-5 удаа

Нэг удаагийн галлалтанд зарцуулагдсан түлшний хэмжээ ба төрөл: Тостой нимгэн боодлын цаас 20 г, нарс мод 0.4-0.5 кг, Налайхын нүүрс 5-5.5 кг.

Туршилтын хугацаа: 12 дүгээр 01-нээс 01 дүгээр сарын 31

Цаг уурын нөхцөл: Агаарын дундаж температур -26°C , агаарын дундаж даралт 1200 гПа, салхины дундаж хурд 0.6 м/с.

Хөөг авсан хугацаа: 2 сар

IV. Хөөний ангилал

Энэ дээжийг гарган авахад хэрэглэсэн яндан тус бүр 0.67 м урттай 5 үеэс тогтох бөгөөд бид хамгийн дээд үеийг 1, дараагийн үеийг 2, гэх мэтээр дугаарлаж эхний 4 үе тус бүр дээр суусан хөөг цэвэрлэн авав (Зураг 1). Энэ туршилтыг гурван удаа хийлээ. Яндангийн үе бүрд суусан хөөний хэмжээг доорхи хүснэгтэд үзүүлэв.


Хүснэгт 1. Үе бүрд тогтсон хөөний хэмжээ

Үеийн дугаар, n	1	2	3	4	Суурь үе
m, г	54.35	95.61	43.17	58.82	90.53

Яндангаас хялбар салах өнгөн үеийн нунтаг хөөг салгаж авсаны дараа нэлээд бэхжсэн хөөний нимгэн үе бас үлддэг. Энэ үед харгалзах хөөг суурь үе гэж нэрлэв. Харин яндангийн 5 дугаартай үе дээр хөө маш бага хэмжээгээр суух ба энд ихэвчлэн дэгдэмхий үнс суусан байдаг. Энэ нь идэвхитэй шаталтын явцад яндангийн доод үе халснаас суусан хөөний үе шатаж дуусдагтай холбоотой юм. Энэ хэсэгт харгалзах үнсний найрлага тунагч үнсний найрлагатай ойролцоо гэж үзээд энэ хэсгийн хөөнд анализ хийгээгүй болно. Харин үүний оронд шаталтын дараа үлдэх тунагч үнсийг авч анализ хийлээ.

V. Хөө болон үнсний рентген дифракцийн судалгаа

Бид дээр өгүүлсэн байдлаар гарган авсан 6 нунтаг дээжид рентген дифракцийн судалгааны арга ашиглан бүтцийн анализ хийсний дүнд хөө,



Зураг 1. Зуух ба яндан

үнсний доторхи талст болон аморф фазын агуулга, шинж чанарыг тогтоох судалгааг хийлээ. Судалгаанд MAXima_X XRD-7000 маркийн рентген дифрактометр багажийг

ашигласан бөгөөд туршлагад зэс анод, Ni фильтертэй (характеристик шугамын долгионы урт нь $\text{CuK}\alpha 1 = 1.5406 \text{ \AA}$) рентген хоолойн хүчдэл, гүйдлийн утга 40кВ, 30мА, Брэггийн өнцгийн муж, гониометрийн өнцгийн алхам, нэг өнцөг алхамд детекторын бүртгэх хугацаа, цацрагийг багцлагч болон цуглуулагч завсаруудын хэмжээ, байх хэмжилтийн нөхцөлд бүх урьдчилан бэлтгэсэн дээж бүрийн рентген дифрактограммуудыг бичиж авав. Хэмжилтийн үр дүнг боловсруулахдаа олон улсад зөвшөөрөгдсөн талст нэгдлийн дифрактограммын ICSD болон ICDD-PDF2 өгөгдөлийн сангуудтай X'Pert HighScore Plus v2.0a програм хангамжийг ашиглалаа. Дээжүүдийн талст фазын чанарын анализын үр дүнг хүснэгт 2-д, тунагч үнс болон хөөний суурь үеийн рентген дифрактограммуудыг зураг 2-д тус тус үзүүлэв.

Хөө, үнсэнд агуулагдаж байгаа талст болон аморф фазын агуулгыг тогтоохдоо бодисын талст бүтцийн судалгаанд өргөн хэрэглэгддэг Ритвельдийн аргад суурилсан фазын тоон анализын аргыг ашиглав. Дээж дэх талст болон аморф фазуудын бодит агуулгыг үнэн зөв үнэлэхийн тулд судлах дээжид зориудаар дотоод стандарт талст фазыг тодорхой хувиар нэмж өгөөд түүний дифрактограммд Ритвельдийн аргаар үр дүнгийн боловсруулалтыг хийдэг. Уг судалгааны ажилд дотоод стандарт талст фазаар цахиурын NIST 640с (Si, 99.99%, 320миш) стандартыг ашиглав. Судалж буй нунтаг дээжид m тооны талст фазуудаас гадна аморф фаз A хэмжээтэй оршин байгаа үед талст болон аморф фазуудын агуулга хооронд дараах холбогдол байна гэж үздэг:

$$\sum_{i=1}^m X'_i = 1 - A, \quad (1)$$

энд: X'_i -дээж дэх i -рталст фазын бодит агуулга.

Харин X'_i болон A хэмжигдэхүүн бүр нь харгалзан дараах томьёонуудаар илэрхийлэгдэнэ [5]:


$$X'_i = X_i \cdot \frac{R_s}{X_s} \cdot \left(\frac{1}{1 - R_s} \right), \quad (2)$$

$$A = \left(\frac{1}{1 - R_s} \right) \cdot \left(1 - \frac{R_s}{X_s} \right), \quad (3)$$

энд: R_s -судлах дээжид зориудаар нэмж өгсөн дотоод стандарт талст фазын бодит агуулга,

Хүснэгт 2. Хөө, үнсний рентген дифракцийн фазын чанарын анализын дүн

ICDD өгөгдөлийн сан дахь дугаар	Эрдсийн нэр	Химийн томъёо	Талст бүтцийн өгөгдөл
00-037-1496	Ангидрит	CaSO ₄	Триклин, Bmmb (63), a=6.99Å, b=7.00Å, c=6.24Å, V=305.60Å ³ , Z=4
00-046-1045	Кварц	SiO ₂	Тригональ, P3221 (154), a = 4.91Å, c=5.40Å, V=113.01Å ³ , Z=3
00-076-0603	Гематит	Fe ₂ O ₃	Ромбо, R-3c (167), a=5.03Å, c=13.74Å, V=301.75Å ³ , Z=6
00-0741905	Гипс	CaSO ₄ ·2(H ₂ O)	Моноклин, C12/c1 (15), a=5.68Å, b=15.18Å, c=6.52Å, β=118.38°, V=494.61Å ³ , Z=4
00-024-0719	Гексагидрат	MgSO ₄ ·6(H ₂ O)	Моноклин, A2/a (15), a=24.44Å, b=7.21Å, c=10.11Å, β=98.28°, V=1766.12Å ³ , Z=8
00-026-1079	Графит	C	Ромбо, R3 (146), a=2.45Å, c=10.04Å, V=52.47Å ³ , Z=6
00-081-0464	Геотит	FeO(OH)	Триклин, Pbnm (62), a=4.60Å, b=9.95Å, c=3.02Å, V=138.64Å ³ , Z=4
00-086-2339	Кальцит	Ca(CO ₃)	Ромбо, R-3c (167), a=4.98Å, c=17.12Å, V=368.31Å ³ , Z=6
00-009-0466	Альбит	NaAlSi ₃ O ₈	Моноклин, C12/m1 (12), a=8.14Å, b=12.78Å, c=7.16Å, α=β=90°, γ=87.67°, V=664.84Å ³ , Z=4
00-078-0639	Кальцийн исэл	CaO	Куб, Fm-3m (225), a= 4.80Å, V=110.94Å ³ , Z=4



Зураг 2. Хөөний суурь үе, тунагч үнсний рентген дифрактограмм

Хүснэгт 3. Хөө, үнсний рентген дифракцийн фазын тоон анализын дүн

Эрдсийн нэр	Химийн томъёо	Дээжийн дугаар ба талст болон аморф фазын агуулга, [%]					
		Үнс	Суурь үе	IV-р үе	III-р үе	II-р үе	I-р үе
Ангидрит	CaSO ₄	10.492	3.716	9.307	6.836	6.287	5.418
Кварц	SiO ₂	18.881	0.528	2.489			
Гематит	Fe ₂ O ₃	2.128	2.602				
Гипс	CaSO ₄ ·2(H ₂ O)			0.444	0.859	2.400	4.835
Гексагидрат	MgSO ₄ ·6(H ₂ O)			2.566	4.099		
Графит	C		3.855		3.321	2.572	4.782
Геотит	FeO(OH)					5.872	4.565
Кальцит	Ca(CO ₃)	5.380					
Альбит	NaAlSi ₃ O ₈	9.828					

Кальцийн исэл	CaO	2.822					
Аморф фаз		50.470	89.297	85.192	84.882	82.865	80.397

X_s -дотоод стандарт талст фазын Ритвельдийн аргаар тооцоологдсон агуулга. Энэ нь X_i -ийн адил Р. Ж. Голм, К. Ж. Говард, (1987 он) нарын ажилд үзүүлснээр дараах байдлаар тодорхойлогдоно [5, 6]:

$$X_i = \frac{s_i \cdot (ZMV)_i}{\sum_j^m s_j \cdot (ZMV)_j}, \quad (4)$$

энд: s_i нь i -р талст фазад хамаарах пикийн эрчимийн масштабын коэффициент. $(ZMV)_i$ үржвэрт буй Z нь i -р талст фазын эгэл үүр дэх атом (молекул)-ын тоо, M нь атом (молекул)-ын масс бол V нь эгэл үүрийн эзэлхүүн. Ритвельдийн аргад суурилсан фазын тоон анализын үр дүнг сайжруулахын тулд хэмжилт болон тооцооны систематик алдааг хамгийн бага байлгах хэрэгтэй болдог. Ритвельдийн арга ашиглан хөө, үнсний дээрх дээжүүдэд хийсэн фазын тоон анализын үр дүнг хүснэгт 3-д үзүүлэв.

VI. Үр дүн ба хэлэлцүүлэг

Хөөнд хийсэн фазын тоон анализын дүнгээс үзэхэд түүнд талст тогтоцтой нүүрстөрөгчийн графит бүтэц (Ромбо, R3 (146), $a=2.45\text{\AA}$, $c=10.04\text{\AA}$, $V=52.47\text{\AA}^3$, $Z=6$) болон шатаасан нүүрсэнд агуулагдах элементүүд (S, Ca, Fe, Na, Si, Al, Mg), шаталтын явцад бий болсон нэгдлүүд (CaSO_4 , SiO_2 , Fe_2O_3 , $\text{CaSO}_4 \cdot 2(\text{H}_2\text{O})$, $\text{MgSO}_4 \cdot 6(\text{H}_2\text{O})$, $\text{Ca}(\text{CO}_3)$, $\text{NaAlSi}_3\text{O}_8$) талст бүтэц үүсгэн агуулагдаж байдаг нь тодорхой харагдаж байна. Энэ нь бусад судалгааны үр дүнтэй сайн тохирч байна [7]. Мөн хөөний суух өндөр өсөхөд кальцийн ангидрид буурч байхад, гипс нь өссөн хандлага ажиглагдаж байна. Харин графит нь яндангийн үе бүхэнд харилцан адилгүй, 3-5%-ын хооронд агуулагдаж байна. Хөөний доторхи аморф фазын хэмжээ үнстэй харьцуулахад маш их бөгөөд харин үеийн өндөр ихсэх тусам илт буурч байгаа нь энэ фазын үүсэлд температурын нөлөө их байдгийг харуулж байна. Шаталтын хамгийн их температур шатаж буй нүүрсний гадаргуу дээр ажиглагддаг бөгөөд 1200°C байдаг бол яндангийн дөрөв дүгээр үед 500°C -аас бага болсон байдаг. Ийм учраас идэвхитэй явагдаж байгаа бүсээс гарсан хий яндангаар дамжин гадагшлах явцдаа маш огцом хөрдөгтэй холбоотойгоор ийм аморф бүтэц үүсдэг гэсэн дүгнэлт хийж болох юм.

Анализын дүнд гарч ирж байгаа төмрийн ислүүд нь ихэвчлэн яндангийн материалын зэврэлттэй холбоотой гэж үзэж болох боловч үнс болон яндангийн дээд үеүд дэх хөөнд ажиглагдаж байгаа нь нүүрсэн дэх төмрийн агууламжтай холбоотой гэх дүгнэлтэд хүргэдэг. Иймд үнсэнд агуулагдаж байгаа төмрийн исэл нүүрсний үл шатах хэсэгт агуулагддаг гэдгийг, харин яндангийн дээд үеүдэд илэрч байгаа төмрийн исэл нь шатамхай нэгдэл хэлбэрээр орших хэсэгт орших төмөр агаарын чийг ихтэй хэсэгт очиж конденсацилсанаар үүсдэг болохыг харуулж байна. Фазын тоон анализар үнэлэгдсэн талст фазуудын агуулгын хэмжээнээс үзэхэд нүүрсэнд байгаа төмөр ихэвчлэн шатамхай нэгдэлтэй холбогдсон байдаг байна. Дээж бүрийн рентген дифракто-грамуудад Ритвельдийн аргаар боловсруулалт хийж гарган авсан үр дүнгүүдийн үнэмшил хэр байгааг үзүүлэх шалгуур факторуудын утгуудыг тооцоолоход бүх дээжийн хувьд харгалзан $R_{exp} = 3.14 \div 5.15$, $R_{wp} = 4.16 \div 6.11$, $R_p = 3.29 \div 4.82$, $GoF = 1.40 \div 2.21$ хязгаарт оршиж байв. Энэ нь бидний хөө, үнсэнд хийсэн фазын тоон анализын үр дүн үнэнд нэлээд ойр болсныг харуулж байна. Энэ анализад хөө болон суурь үеийн рентген дифрактограммууд дахь кварц болон графитийн пикүүдийг ялгаж тогтооход нилээд бэрхшээлтэй байсныг тэмдэглэе. Эдгээр талст фазуудын агуулга харьцангуй бага бөгөөд ойролцоо байгаагийн улмаас хамгийн их эрчимтэй пикээс бусад бага эрчимтэй пикүүд ялгагдахгүй байв. Синтетик графитийн рентген дифрактограмм нь Брэггийн өнцгийн $2\theta = 5^\circ - 60^\circ$ мужид 26.8° , (002), 100%; 42.3° , (100), 11%; 44.5° , (101), 9%; 54.9° , (102), 6% гэсэн дөрвөн онцлог пикүүдийг үзүүлдэг (энд жагсаасан гурван тооны эхнийх нь тухайн пикэд харгалзах Брэггийн өнцөг бол хоёрдахь нь дифракц өгсөн хавтгайн Миллерийн индекс, гуравдахь нь тухайн талст фазаас өгөх пикийн харьцангуй эрчим болно). Мөн тасалгааны температурт хэмжигдсэн α -кварцын рентген дифрактограмм нь Брэггийн өнцгийн $2\theta = 20^\circ \div 60^\circ$ мужид 20.8° , (100), 22%; 26.6° , (101), 100%; 50.1° , (112), 14%; 59.9° , (211), 9% гэсэн дөрвөн онцлог пикийг өгдөг. Бидний судалсан хөөний хувьд

графитын эхний пик, кварцийн хоёр дахь пик давхцаж ажиглагдаж байна. Үүнийг ялгахдаа

бид өөр мужид гарч ирдэг өндөр эрчимтэй пикүүдийг авч үзсэн болно.

-
- [1] AndrásGelencsér, “Carbonaceous Aerosol”, Springer, (2004)
 - [2] H.Furutani, S.Tsuge, and S.Goto, "The Dependence of Carbon/Hydrogen Ratio on Soot Particle Size," SAE Technical Paper 920689, (1992)
 - [3] C.K.Law, “Combustion physics”, Cambridge University Press, (2006)
 - [4] P.Lu, C.Li, “Research on soot of black smoke from ceramic furnace flue gas: Characterization of soot”, Journal of hazardous material, **272**, 199, (2012)
 - [5] R.Snellings, L.Machiels, G.Mertens and J.Elsen, “Rietveld refinement strategy for quantitative phase analysis of partially amorphous zeolitized tuffaceous rocks”, *Geologica Belgica*, **13/3**, 183, (2010)
 - [6] R.J.Hill, C.J.Howard, “Quantitative phase analysis from neutron powder diffraction data using the Rietveld method”, *J. Appl. Cryst.* **20**, 467, (1987)
 - [7] A.Minjigmaa, Ts.Zolzaya, E.Bayanjargal, B.Davaabal, J.Temuujin, “Characterization of ash pond ashes from 3rd thermal power plant by SEM/EDX and XRD methods”, *Mongolian Journal of Chemistry* **14** (40), 61, (2013)

Цахилгаан Шүүлтүүр Дотор Явагдах Титэмт Ниргэлгийн Хязгаарын Параметруудийг Тооцоолох нь

Ж.Ванчинхүү, П.Мөнхбаатар, Б.Бат-эрдэнэ, Ш.Мөнхжаргал
Физикийн тэнхим, ШУС, МУИС

Цахилгаан шүүлтүүрт явагдах титэмт ниргэлэг үүсэх болон стример шилжих нөхцөлийг судалж стационар титэмт ниргэлэг явагдаж байх хүчдэл, гүйдлийн хамгийн их ба хамгийн бага утгын хязгаарыг тооцоолов. Түүнчлэн иончлолын коэффициентийн орноос хамаарах хамаарал мэдэгдэж байгаа тохиолдолд титэмт ниргэлгийн асаах хүчдлийн утгыг онолын хувьд гаргах боломжтойг үзүүлж титэмт ниргэлгийн доторхи цахилгаан орон ба ионы түгэлт гаргав.

PACS number: 52.80.Hc, 47.57.-s

I. Оршил

Тодорхой хурдтай хөдөлж байгаа цэнэгтэй бөөмийг цахилгаан оронд оруулахад түүнд орны зүгээс Кулоны хүч үйлчилдэг. Энэ цэнэгийн хөдөлгөөний анхны чиглэл нь орны чиглэлээс ялгаатай байвал бөөм анхны чиглэлээс хазайн орны дагуу хөдөлдөг. Цахилгаан орон дотор хөдөлж байгаа цэнэгт бөөмийн хөдөлгөөний энэ чанарыг ашиглан дисперслэгдсэн жижиг хэсгүүд агуулсан орчныг жижиг хэсгүүдээс нь шүүж цэвэрлэдэг бөгөөд ийм системийг цахилгаан шүүлтүүр гэдэг [1-3]. Тоосны ширхэгүүд, микродуслууд болон бөөмцөр зэргийг агуулсан хий болон дисперслэгдсэн системийг шүүж цэвэрлэхэд ийм цахилгаан шүүлтүүрийг өргөн ашигладаг [4-6]. Шаталтаас ялгарах утаа нь шаталтын явцад үүсэх төрөл бүрийн хий болон хөө тортогийг бүрдүүлэгч харьцангуй том хэмжээтэй бөөмцрүүд (дисперслэгдсэн систем) агуулсан олон фазтай систем байдаг [7,8]. Ийм учраас утааг хөө тортогоос нь цэвэрлэхэд цахилгаан шүүлтүүрийг үр ашигтайгаар ашиглаж болно.

Цахилгаан шүүлтүүрийн шүүх чадвар нь хийн урсгалын хурд, бөөмцрийн хөндлөн чиглэлд хөдлөх дрейфийн хурднаас хүчтэй хамаардаг [1,4]. Харин дрейфийн хурдны хэмжээ нь шүүлтүүрийн доторхи цахилгаан орны түгэлт болон бөөмцрийн цэнэгийн хэмжээнээс хамаарч байдаг [2,3].

Утааны бөөмцрийн цахилгаан статик шүүлтүүр зөвхөн цэнэгтэй бөөмцрийг шүүж чадах учраас бөөмцрийн цэнэг болон шүүлтүүрт өгч буй орны хэмжээ нь шүүлтийн зэрэгт нөлөөлөх гол хүчин зүйлүүд болж байдаг. Цахилгаан оронд байгаа иончлогдсон хийн орчин дотор буй бөөмцрийн олж авах цэнэгийн хэмжээ нь орны утга болон түүний шугаман хэмжээнээс хамаарч байдаг. Цахилгаан шүүлтүүр ашиглан утааны хөө тортогийг шүүхийн тулд бөөмцрүүдийг янз бүрийн процессууд ашиглан цэнэглэж болох

боловч утааны шүүлтүүрт хамгийн тохиромжтой, энгийн хямд төсөр цэнэглэх арга нь титэмт ниргэлэг [2,3,9] юм. Түүнчлэн титэмт ниргэлгийг үүсгэж буй гаднын орныг бөөмцрийг хийн урсгалын бүсээс зайлуулахад давхар ашигладаг. Титэмт ниргэлэг тодорхой нэг хүчдлийн утгаас эхлэн явагдаж эхлэх бөгөөд цаашид хүчдлийг өсгөхөд тодорхой нэг утганд хүрээд ниргэлэг өөр горимд шилжинэ. Энэ тохиолдолд шүүлт явагдахаа больдог. Ийм учраас цахилгаан шүүлтүүрийн ажиллах хязгаар нь титэмт ниргэлэг үүсэх болон түүнээс ниргэлгийн өөр горимд шилжих параметруудийн утгаар тодорхойлогдоно. Энэ өгүүлэлд цахилгаан шүүлтүүрийн дотор явагдах титэмт ниргэлгийн хязгаарын параметруудийг тооцоолох асуудлыг авч үзлээ.

II. Титэмт ниргэлэг, түүний үүсэх нөхцөл

Хоёр электродын хооронд хүчдэл өгөхөд тэдгээрийн хооронд цахилгаан орон үүснэ. Энэ орны түгэлт электродын хэлбэр, харилцан байршлаас хамаарна. Тухайлбал агаар дотор байгаа тэнхлэгүүд нь давхацсан R_0 , r_0 радиустай хоёр цилиндрийн хооронд V хүчдэл өгөхөд тэдгээрийн хооронд үүсэх орон тэнхлэгээс r зайд $E = \frac{V}{r \ln(\frac{R_0}{r_0})}$ байна. Энэ функц r_0 -ийн орчим маш хүчтэй нэгэн төрөл биш чанартай байдаг. Харин орны хамгийн их утга $E_{max} = \frac{V}{r_0 \ln(\frac{R_0}{r_0})}$ дотоод цилиндрийн гадаргуу дээр үүсдэг. Орны энэ утгаар тэнхлэг нь давхацсан цилиндрүүдийн хоорондох орны утгыг илэрхийлбэл

$$E = \frac{E_0 r_0}{r} \quad (1)$$

байна. Энэ орны хүчлэгийн градиент $\frac{\partial E}{\partial r} = -\frac{V}{r^2} \ln(\frac{R_0}{r_0})$ байх учраас орон их муруйлттай хурц электродын орчим маш хүчтэй төрөл бус байна.

Хурц электродын орчимд байгаа электрон хүчтэй орны нөлөөгөөр анодын зүг хөдлөхдөө хурдасч богино зайд их энерги олж авна. Энэ электроны энерги хийн орчны атом, молекулыг иончлох хэмжээнд хүрсэн үед нейтраль бөөмтэй мөргөлдөхдөө түүнийг иончилно. Анхны ба шинээр үүссэн электрон орны үйлчлэлээр дахин хурдасч дахин иончлол явуулна. Титэмт ниргэлэг дотор электронууд ийм байдлаар үржин олширч замдаа эерэг ионуудын мөр үлдсэн анод руу чиглэн хөдөлж байдаг. Электроны ингэж үржин олширох процесс хурц электродын орчим дахь өндөр хүчлэгтэй муж дотор явагдах боломжтой бөгөөд харин электрон хурц электродоос холдож сул орны мужид орох үед электрон чөлөөт замын уртын зайд иончлох хэмжээний энерги олж авч чадахгүй учраас электроны үржин олширох процесс зогсдог. Электрон үржин олширох мужид иончлолоос гадна өдөөлтийн процесс зэрэгцэн явагдаж байдаг учраас хурц электродын орчим сулхан хөх ягаан гэрэл үүсдэг. Энэ хэсгийг титэм гэж нэрлэх бөгөөд энэ утгаар нь хурц электродыг титэмлэгч электрод гэдэг. Энэ мужийн гэрлийн спектрт хөх, ягаан өнгө давамгайлж байдаг нь энэ мужид их энергитэй электронууд байгааг харуулж байгаа хэрэг юм. Шүүлтүүр дотор титэмт ниргэлэг тогтвортой асаж байгаа тохиолдолд бөөмцийн шүүлт тасралтгүй явагддаг тул ниргэлэг стационар байх нөхцөл чухал ач холбогдолтой. Энэ нөхцөлийг судалъя.

III. Ниргэлэг стационар асах нөхцөл

Анод катодын хооронд үүсгэсэн цахилгаан оронд байгаа хий дундуур орны дагуу дрейфлэн хөдөлж байгаа нэг электрон 1 см туулахдаа үүсгэх (атомтай мөргөлдөж) электрон ионы хосын тоог α гэе. Үүнийг Таунсендын иончлолын коэффициент гэдэг. Катодын зүгээс хөдөлсөн N_0 электрон l зам туулахдаа $N_0 e^{\alpha l}$ тооны болж очно. Ийм байдлаар электронуудын үржин олширол явагдана. Нөгөө талаас стационар ниргэлэг явагдаж байхын тулд үржин олширох процессийг бий болгогч анхдагч электронууд байнга үүсэж байх ёстой. Ийм электронууд ион катодыг мөргөсний дүнд явагдах хоёрдогч электроны эмиссээр үүсдэг. Нэг ионы катодоос сугалах электроны тоо $\gamma = \frac{n_e}{n_i}$ -г хоёрдогч электроны эмиссийн коэффициент гэдэг. Тэгвэл нэгэн төрлийн тогтмол орны тохиолдолд ниргэлэг стационар асах нөхцөл дараах хэлбэртэй байна:

$$\alpha L = \ln \left(1 + \frac{1}{\gamma} \right). \quad (2)$$

энд: L -электродуудын хоорондох зай.

Титэмт ниргэлгийн хувьд орон нэгэн төрөл биш учраас дээрх нөхцөлийг нэгэн төрлийн бус орны тохиолдолд өргөтгөн тодорхойлох ёстой. Нэгэн төрлийн биш орон дотор электрон хөдлөх явцад үүсэх электроны тоо орны утгаас хамаарна. Иймээс иончлолын коэффициент орноос хамаарсан $\alpha = \alpha(E(r))$ функц байна. Нөгөө талаас электронууд атомтай мөргөлдөх үедээ түүнд нэгдэн (аттэчмент) алга болж электроны тоо цөөрөх тул иончлолын коэффициентээс электроны аттэчментийн коэффициент a -г хасаж өгөх хэрэгтэй. Иймд нэгэн төрлийн бус орны тохиолдолд ниргэлэг стационар асах нөхцөл дараах хэлбэрт шилжинэ:

$$\int_{r_0}^R [\alpha(E(r)) - a] dr = K, \quad (3)$$

энд: r_0 -катод буюу титэмлэгч электродын радиус, R -катодын тэнхлэгээс электроны үржин олширох процесс зогсох цэг хүртлэх зай.

Дээрх тэнцэтгэлд агуулагдаж байгаа K коэффициентийг өмнөхийн адил дан ганц хоёрдогч эмиссээр үүсдэг гэж үзэж болохгүй. Энэ нь ниргэлгийн явцад явагдах фотоиончлол, ионы мөргөлт зэрэг процессуудын дүнд үүсэж байгаа электронуудын нийлбэрээр тодорхойлогдоно. Ниргэлгийн явцад электроны шууд иончлолоор үүсэх электронууд бүгдээрээ аттэчментээр алга болж байвал үржин олширох процесс тасарна. Ийм учраас энэ интегралын дээд хязгаар $\alpha(E(R)) = a$ нөхцөлөөр тодорхойлогдоно.

Орчин үеийн ниргэлгийн судалгаануудад эффектив иончлолын коэффициентийн хувьд дараах туршлагын функцийг хэрэглэдэг [3]:

$$\alpha_{эфф} = \alpha(E(r)) - a = 0.14\delta \left(\left(\frac{E}{31\delta} \right)^2 - 1 \right), \quad (4)$$

энд: E [кВ/см]-цахилгаан орон, $\delta = 0.386p/(273 + t)$ -агаарын харьцангуй нягт, p -агаарын даралт, t -Цельсийн температур. Энд буй цахилгаан орны хувьд коаксиаль цилиндрийн орныг авч стационар ниргэлгийн нөхцөлд тооцвол:

$$\int_{r_0}^R \left[0.14\delta \left(\left(\frac{E_0 r_0}{31\delta r} \right)^2 - 1 \right) \right] dr = K. \quad (5)$$

Энэ интегралыг титэмлэгч электродын гадаргуугаас эхлэн электроны үржин олширох процесс дуусах цэг хүртэл буюу $\alpha_{эфф}(R) = 0$ нөхцөлийг хангах цэг хүртэл авах ёстой. Иймээс интегралын дээд хязгаар

$$R = \frac{E_0 r_0}{31\delta} \quad (6)$$

гэж тодорхойлогдох ба интеграл дараах хэлбэрт шилжинэ:

$$\int_{r_0}^{\frac{E_0 r_0}{31\delta}} \left[0.14\delta \left(\left(\frac{E_0 r_0}{31\delta r} \right)^2 - 1 \right) \right] dr = K. \quad (7)$$


Энэ интегралыг бодвол дараах үр дүнд хүргэнэ:

$$-\frac{E_0 r_0}{31\delta} + \left(\frac{E_0}{31\delta} \right)^2 r_0 - \frac{E_0 r_0}{31\delta} + r_0 = \frac{K}{0.14\delta}.$$

Эндээс стационар титэмт ниргэлэг асахын тулд катодын орон ба титэмлэгч электродын радиусын хооронд дараах харьцаа биелэхийг тогтоож болно:

$$E_0 = 31\delta \left(\sqrt{\frac{K}{0.14\delta r_0}} + 1 \right). \quad (8)$$

Үүнийг Пикийн хуультай [9] жишвэл $K = 0.013$ гэж олдоно. Энэ нь титэмт ниргэлэгтэй цахилгаан шүүлтүүрийн хувьд чухал хэрэглээ бүхий томьёо юм. Энэ томьёог ашиглан стационар ниргэлэг явагдаж байхын тулд катод (титэмлэгч электрод) дээрх орны утга E_0 ба титэмлэгч электродын радиусын хоорондын хамаарлыг температурын өөр өөр утганд гаргаж болно (Зураг 1). Хэдийгээр энэ хууль туршлагын томьёо боловч иончлолын эффектив огтлолын хэлбэр мэдэгдэж байгаа тохиолдолд үүнийг онолын хувьд гаргах боломжтой гэдэг нь эндээс харагдаж байна. Асаах орны утгын энэ илэрхийлийг ашиглан хүчдлийн ямар утганд титэмт ниргэлэг явагдаж эхлэхийг тодорхойлж. Асаах орны утгыг тэнхлэг нь давхацсан цилиндрүүдийн хоорондох орны түгэлтийн томьёонд



Зураг 1. Асаах орны утга титэмлэгч электродын радиусаас хамаарах нь.

орлуулбал ниргэлэг асах хүчдлийн утга титэмлэгч электродын радиусаас хамаарч дараах байдлаар илэрхийлэгдэнэ:

$$V_0 = 31\delta r_0 \ln \left(\frac{R_0}{r_0} \right) \left(\sqrt{\frac{K}{0.14\delta r_0}} + 1 \right). \quad (8)$$

Хүчдлийн энэ утгаас бага $V < V_0$ хүчдлийн утганд титэмт ниргэлэг үүсэхгүй. Харин хүчдлийн энэ утгаас эхлэн ниргэлгийн гүйдэл бүртгэгдэж эхлэх бөгөөд асаах хүчдлийн утганд харгалзах гүйдэл нь титэмт ниргэлэгийн гүйдлийн хамгийн бага утга юм. Энэ гүйдлийн утгыг бид сүүлд гаргах болно. Асаах хүчдлийн утга титэмлэгч болон цуглуулагч электродын радиусаас голлон хамаардаг (Зураг 3).

Титэмт ниргэлэг явагдаж эхлэх E_0 орны утгыг авч үзье. Энэ утгыг янз бүрийн орчинд титэмт ниргэлэг асаах замаар туршлагаар тогтоож болно. Ердийн агаар дотор бие даасан ниргэлэг явж эхлэхэд гүйдлийн утга 1 мкА хүртэл үсэрдэг. Иймээс электродуудын хооронд хүчдэл өгч гүйдлийг хэмжих замаар гүйдлийн үсрэлт эхэлж байгаа хүчдлийн утгыг тодорхойлоод үүнд харгалзуулан ниргэлэг асах үеийн катод дээрх орныг $E_0 = \frac{V}{r_0 \ln \left(\frac{R_0}{r_0} \right)}$

томьёогоор бодож олно. E_0 -г олсон тохиолдолд d титэмлэгч үеийн зузааныг мөн туршлагаар тогтоох боломжтой болно. Титэмлэгч үеийн зузааныг хэмжиж олсноор бага орны мужийн өргөн буюу бөөмцөр цэнэглэгдэх мужийн өргөнийг ч мөн тодорхойлох боломжтой.

IV. Титэмт ниргэлэг дэх цахилгаан орон ба цэнэгийн түгэлт

By our team's previous study, 87% of Ulaanbaatar air pollution (PM_{2.5}) caused by raw coal combustion in households stove for heating. Government of Mongolia and Ulaanbaatar city authorities have taken a number of measures to solve the air pollution problems such as subsidizing improved coal stoves (producing less smog), cleaner fuels such as semi-coke (also thought to produce less smog), Heat Only Boiler reconstruction work, converting ger district area to

apartment district and development of paved road near to Zuun Ail area.

V. SUMMARY

Working group has done round year measurement at the Zuun Ail Testing Point and collected 132 samples of PM_{2.5} and PM_{2.5-10}. All samples are analyzed by XRF and BC is determined into all those samples. Measurement result shows that, in 2012/2013, PM_{2.5} and PM₁₀ emission is reduced 2 times than 2008/2009 at Zuun Ail due to GoM's activities to solve air pollution disaster.

- [1] Air Pollution science for 21st Century Jill Austin, Peter Brimblecombe, William Styrges, 2002,
- [2] Indoor Air Quality Survey. Report of study Ministry of Health, Public Health Institute, WHO, ISBN 798-99929-4-146-4 Soil
- [3] Soil Apportionment in Ulaanbaatar City Air Pollution Sources S.Lodoisamba, D.Shagjjamba. Proceedings of International Conference on Contemporary Physics-IV, August 13-20, Ulaanbaatar. Mongolia, 160, (2008)
- [4] Ion Beam Analysis results of air particulate matter collected in Mongolia W.Trompetter, B.Barry, P.Davy, A.Markwitz, G.Gerelmaa. GNS Science consultancy report 2008/198 July 2008.
- [5] Operating manual for GENT sampler. A.Markwitz, 'Improved Information about Urban Air Quality Management (RCA)' New Zealand, (2004)
- [6] Multimental Analysis and Characterization of Fine Aerosols at Several Key ACE-Asia sites, David D.Cohen, David Garton, Eduard Stelcer, Olga Hawas, Tao Wang, Steven Poon, Jiyoung Kim, Byong Cheol Choi, Sung Nam Oh, Hye-Jung Shin, Mi Young Ko and Mitsuo Uemats, Journal of geophysical research, Vol. 109, D19S12.
- [7] <http://www.euro.who.int/pubrequest>

Могодын Хагарлаас Үүсэх Газар Хөдлөлийн Аюулыг Магадлалын Аргаар Үнэлэх нь

Т.Нарангарав, Ц.Баатарчулуун*, Б.Ганбат

Геологи Геофизикийн тэнхим, ШУС, МУИС

Mongolia is considered to be located at the seismic active region and is divided into several tectonic zones. The Mogod earthquake ($M=7.5$, January 1967) which occurred at east of Hangai dome was one of the strongest earthquakes that occurred in the past century in Mongolia. The seismic event was closely studied by several researchers because seismicity of the Central Mongolian region was previously regarded as moderate.

In this study, we have determined the seismic hazard at Bulgan city ($N48048'43''$, $E103032'1''$) and Erdenet city ($N4901'59''$, $E10404'59''$) due to the Mogod fault zone using the probabilistic approach. The distributions of catalogued earthquakes, together with available geological and tectonic information of the Mogod fault region were used to calculate probabilistic seismic hazard parameters.

From the analysis, mean annual rate of exceedance, return period and cumulative probability hazard curve for peak ground acceleration (PGA) have been estimated at Bulgan city and Erdenet city.

PACS numbers: 91.30.P, 91.30.pb, 91.30.pd

I. ОРШИЛ

Эх газар, далай тэнгисийн хил зааг дагуух болон тектоник хагарлуудаар тусгаарлагдсан хавтангуудын харилцан үйлчлэлийн нөлөөгөөр дэлхийн царцдаст мандалд их, бага хэмжээний эвдрэлүүд үүсдэг. Ийнхүү эвдрэл үүссэний улмаас газрын гүнд хуримтлагдсан энерги чөлөөлөгдөн газар хөдлөлт болж уян харимхайн долгион хэлбэрээр дэлхийн дотоод хэсэг болон гадаргуугаар тархана.

Хүчтэй газар хөдлөлтийн улмаас ойр орчмын бүс нутагт хөрсний чичирхийлэл, хөрсний шилжилт, хөрсний гулсалт, цунами, үер, гал түймэр зэрэг аюул учрах боломжтой. Түүнчлэн газрын гадаргууд хагарал үүсч болох ба энэ нь тухайн газарт болох газар хөдлөлтийн үүсвэр болно.

Газар хөдлөлийн аюулаас үүсэх эрсдэлийг бууруулах нэг арга нь тухайн бүс нутагт үүсч болзошгүй хөрсний чичирхийллийг үнэлэх явдал юм.


Энэхүү судалгааны ажлын хүрээнд Могодын хагарлын улмаас үүсэх газар хөдлөлийн аюулыг магадлалын аргаар Булган ба Эрдэнэт хотуудын хувьд үнэлэв.

II. СУДАЛГААНЫ ТАЛБАЙН ТЕКТНИК ОНЦЛОГ

Монгол орны нутаг дэвсгэр нь газар хөдлөлийн идэвхтэй бүсэд хамаардаг бөгөөд хэд хэдэн тектоник мужуудад хуваагддаг.

Монголын нутаг дэвсгэрт болж байгаа идэвхтэй тектоникийн хөдөлгөөн нь гарал үүслийн хувьд Индостаны микроконтинент Евразитай коллизод орсонтой холбоотой. Энэхүү коллизын улмаас Алтай, Хангай,

Хөвсгөл болон Хэнтийн уулсын тогтолцоо үүссэн бөгөөд уг тогтолцоо нь Монголын ба Амурын гэсэн хоёр плитийг заагладаг. А.Баясгалан, С.Хишигсүрэн (2009) нарын үзэж байгаагаар Амурын микроплит зүүн-урагш, Монголын микроплит баруун-хойш ойролцоогоор 5.2мм/жил хурдтай тус тус хөдөлж байна [1-3].



Зураг 1. Могодын хагарал орчмын газар хөдлөлийн эпицентрийн түгэлт болон магнитудын хэмжээ.

Могодын хагарал нь хойноос урагш чиглэсэн шилжил (strike-slip fault) бөгөөд ба тектоник мужлалаар Төв Монголын Хангайн бүсэд хамаардаг [2].

Статистик тоо баримтаас үзэхэд 1964 оноос хойш уг хагарлын орчимд $M=3.5$ -аас дээш магнитудтай газар хөдлөл жилд дундажаар 5-6 удаа болсон ба хамгийн хүчтэй нь 1967 оны 1 сарын 5-нд 7.5 магнитудын хүчтэй үндсэн газар

хөдлөл (main shock), 1967 оны 1 сарын 20-нд 7.0 магнитудын хүчтэй дагалдах газар хөдлөл (aftershock) болсон. Энэ нь сүүлийн 100 жилд Монгол орны нутаг дэвсгэрт болсон хүчтэй газар хөдлөлүүдийн нэг юм.

Могодын хагарал орчимд бүртгэгдсэн газар хөдлөлийн эпицентрийн түгэлт болон магнитудын хэмжээг Зураг 1-д үзүүлэв.

III. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Тектоник хагарлууд нь янз бүрийн хэмжээ (ө.х. магнитуд)-тэй газар хөдлөлийг үүсгэх боломжтой. Тухайн бүс нутаг дахь газар хөдлөлийн хэмжээ нь тодорхой түгэлттэй байдаг ба энэ нь Гутенберг-Рихтерийн давтагдлын хуулиар илэрхийлэгдэнэ [4]:

$$\log \lambda_m = a - b \cdot m \quad (1)$$

Энд: λ_m – магнитудын тодорхой утгаас их магнитудтай газар хөдлөлтийн тоо, a , b – тухайн бүс нутгийн газар хөдлөлийн идэвхжилийг илэрхийлсэн тогтмолууд.

Тектоник хагарлын улмаас үүсэх газар хөдлөлийн учруулж болох аюул нь газар хөдлөлийн хүч, хөрсний шилжилтийн эрчим болон тухайн хагарлаас ажиглалтын цэг хүртэлх зайнаас шууд хамаардаг ба дараах томъёогоор илэрхийлэгдэнэ [5]:

$$\lambda(IM > x) = \lambda(M > m_{min}) \cdot \int_{m_{min}}^{m_{max}} \int_{r_{min}}^{r_{max}} P(PGA > x|m, r) \cdot f(m) \cdot f(r) \cdot dr \cdot dm \quad (2)$$

Энд:

$$P(PGA > x|m, r) = \int_x^\infty \frac{1}{\sigma_{\ln PGA} \sqrt{2\pi}} \exp\left(-\frac{1}{2} \left(\frac{\ln u - \ln PGA}{\sigma_{\ln PGA}}\right)^2\right) du \quad (3)$$

$$f(m) = \frac{b \cdot \ln(10) \cdot 10^{-b(m-m_{min})}}{1 - 10^{-b(m_{max}-m_{min})}}, \quad (4)$$

$$f(r) = \frac{r}{L \sqrt{r^2 - x_0^2}} \quad (5)$$

$\lambda(IM > x)$ - хөрсний шилжилтийн эрчмийн утга x -ээс хэтрэх хэмжээ

$\lambda(M > m_{min})$ - m_{min} -аас их магнитудтай газар хөдлөлт болох магадлал

$P(PGA > x|m, r)$ - өгөгдсөн магнитуд ба зайн хувьд ажиглалтын цэгт хөрсний оргил хурдатгал тодорхой утгаас хэтрэх магадлал

$f(m)$ - магнитудын магадлалын нягтын функц


$f(r)$ - зайн магадлалын нягтын функц

b – тухайн бүс нутгийн тектоник идэвхжилийг илэрхийлэх бөгөөд Гутенберг-Рихтерийн давтагдалын хуулиар тодорхойлогдоно

$\overline{\ln PGA}$ – хөрсний оргил хурдатгалын логарифмийн дундаж

$\sigma_{\ln PGA}$ – $\ln PGA$ -ийн стандарт хазайлт

Газар хөдлөл үүсч болох тектоник хагарал болон ажиглалтын цэгийн харьцангуй байршлын геометр параметруудийг Зураг 2-т тоймлон үзүүлэв.



Зураг 2. Хагарал болон ажиглалтын цэгийн байршлын геометр параметруудийн тойм зураг

Бидний авч үзэж буй Могодын хагарал болон ажиглалтын цэгүүд болох Булган ба Эрдэнэт хотуудын байршлын геометр параметруудийн утгуудыг дараах байдлаар тооцов:

$$L = 56.4 \text{ км}$$

Булган хотын хувьд:

$$r_{min} = 50.2 \text{ км},$$

$$r_{max} = 99.5 \text{ км}$$

$$x_0 = 40.6 \text{ км}$$

Эрдэнэт хотын хувьд:

$$r_{min} = 94.3 \text{ км},$$

$$r_{max} = 138.9 \text{ км}$$


$$x_0 = 78.8 \text{ км}$$

IV. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

ШУА-ийн Одон орон, геофизикийн хүрээлэнгийн Үндэсний мэдээллийн төвийн сангаас Могодын хагарлын орчимд бүртгэгдсэн 1964-2013 оны газар хөдлөлийн эпицентрийн байршил болон магнитудын утгыг авч [6] Булган ба Эрдэнэт хотуудын хувьд газар хөдлөлийн аюулыг магадлалын аргаар үнэлэв.


Могодын хагарал орчмын газар хөдлөлийн магнитудын түгэлтийг Гутенберг-Рихтерийн давтагдалын хуулиар тодорхойлсон дүнг Зураг 3-т харуулав.

Эндээс тухайн бүс нутгийн сейсмийн ба тектоникийн параметруудийн утгыг $a=3.230$ ба $b=0.762$ гэж үнэлэв.



Зураг 3. Могодын хагарал орчмын газар хөдлөлтийн магнитудын түгэлт

У.Чандрагийн гаргасан газар хөдлөлийн эрчмийн сулралын хууль [7]-ийг ашиглан Могодын хагарлаас үүсэх газар хөдлөлийн эрчмийн сулралыг үнэлсэн дүнг Зураг 4-т үзүүлэв.



Зураг 4. Могодын хагарлаас үүсэх газар хөдлөлтийн эрчим зайнаас хамаарч сулрах байдал

Ингэхдээ M=6.0, M=6.5, M=7.0 ба M=7.5 магнитуд тус бүрийн хувьд хөрсний оргил хурдатгалын утгыг зайнаас хамааруулан үнэлсэн болно.


Зураг 4-өөс харахад Могодын хагарал орчимд M=7.0 магнитудтай газар хөдлөлт болоход хөрсний оргил хурдатгалын утга Булган орчимд ойролцоогоор 140см/с², Эрдэнэт орчимд ойролцоогоор 60см/с² байна.

Хөрсний оргил хурдатгалын эдгээр утгуудыг В.И.Уломовын томъёолсон

$$\log_{10} \left[\frac{A}{0.301} \right] \cdot I_{(MSK-64)} - 0.107 \quad (7)$$

илэрхийллийг ашиглан хөрсний шилжилтийн эрчим (ground motion intensity)-ээр илэрхийлбэл Могодын хагарал орчимд M=7.0 магнитудын хүчтэй газар хөдлөлт болоход Булган хотод 7.5 балл, Эрдэнэт хотод 6.0 баллын чичирхийлэл мэдрэгдэнэ гэсэн үг юм.

Могодын хагарлын улмаас үүсэх газар хөдлөлийн аюулыг Булган ба Эрдэнэт хотуудын хувьд 100 жилээр тооцсон дүнг Зураг 5-д үзүүлэв.



Зураг 5. Булган ба Эрдэнэт хотуудын газар хөдлөлийн аюулын муруй (100 жилд)

Газар хөдлөлийн аюулын муруйн зургаас үзэхэд Могодын хагарал орчимд газар хөдлөл болоход Булган хот орчмын хөрсний оргил хурдатгалын утга 100см/с² (0.1g)-аас хэтрэх магадлал 100 жилд 9.3% бол Эрдэнэт хот орчмын хөрсний оргил хурдатгалын утга мөн 100см/с² (0.1g)-аас хэтрэх магадлал 100 жилд 0.01% байна.

Ийнхүү тооцохдоо хугацааны эхийг Могодын хагарал орчимд хүчтэй газар хөдлөл болсон хугацаа буюу 1967 оноос тооцсон болно.

Газар хөдлөлийн аюулын давтагдах хугацааг тооцсон дүнг 1-р хүснэгтэд харуулав.

Эндээс үзэхэд Могодын хагарлын улмаас үүсэх газар хөдлөлөөр Булган хот орчмын хөрсний оргил хурдатгалын утга 100см/с² болох тохиолдол 1080 жилд 1 удаа болно.

1-р хүснэгт. Могодын хагарлын улмаас үүсэх газар хөдлөлийн аюулын давтагдах хугацаа

XOX (см/с²)	Давтагдах хугацаа (жил)	
	Булган	Эрдэнэт
20	29	115
40	77	646
60	177	5823
80	423	67763
100	1080	835844
120	2951	9960559

XOX (см/с²)

Давтагдах хугацаа (жил)

Булган Эрдэнэт		
20	29	115
40	77	646
60	177	5823
80	423	67763
100	1080	835844
120	2951	9960559

V. ДҮГНЭЛТ

Могодын хагарлаас үүсэх газар хөдлөлийн аюулыг Булган болон Эрдэнэт хотуудад магадлалын аргаар үнэлсэн дүнгээс дараах дүгнэлтүүдийг хийв. Үүнд:

- Могодын хагарал орчимд $M=7.0$ магнитудтай газар хөдлөлт болоход хөрсний

оргил хурдатгалын утга Булган орчимд ойролцоогоор 140 см/с^2 , Эрдэнэт орчимд ойролцоогоор 60 см/с^2 байна.

- Могодын хагарлаас үүсэх газар хөдлөлийн улмаас хөрсний оргил хурдатгалын утга 100 см/с^2 ($0.1g$)-аас хэтрэх магадлал

- Булган хотын хувьд 100 жилд 9.3%,

- Эрдэнэт хотын хувьд 100 жилд 0.01% байна.

- Газар хөдлөлийн давтагдах хугацааг тооцсон дүнгээс үзэхэд Могодын хагарлын улмаас үүсэх газар хөдлөлөөр Булган хот орчмын хөрсний оргил хурдатгалын утга 100 см/с^2 болох тохиолдол 1080 жилд 1 удаа болно.

-
- [1] Ж.Бямба, Геотектоник, Улаанбаатар (2012)
 - [2] A.Bayasgalan and J.A.Jackson, A re-assessment of the faulting in the 1967 Mogod earthquakes in Mongolia, Geophysical Journal International, **138**, 784 (1999)
 - [3] Е.А.Рогожин, и др., Тектоническая позиция и геологические проявления Могодского землетрясения 5 Января 1967г. в Центральной Монголии (взгляд сорок лет спустя), ФИЗИКА ЗЕМЛИ, 8, 70 (2008)
 - [4] B.Gutenberg, C.F.Richter, Magnitude and Energy of Earthquakes. Annali di Geofisica, **9**, 1 (1956)
 - [5] Jack W. Baker, An Introduction to Probabilistic Seismic Hazard Analysis (PSHA) (2008)
 - [6] ШУА-ийн Одон орон, геофизикийн хүрээлэнгийн Үндэсний мэдээллийн төвийн сан
 - [7] U.Chandra, Attenuation of intensities in the United States, Bulletin of the Seismological Society of America, **69**, 6 (1979)

Алтан Ширээгийн Талбайн Геофизикийн Соронзон Хайгуулын Ажил

Н.Наран-Эрдэнэ*

“Винтрак” ХХК

Алтанширээгийн талбайд 2012 онд хийгдсэн геофизикийн соронзон хайгуулын ажлын үр дүнгээс доорх өгүүлэлд ашиглан геологийн тайлалт хийсэн болно. Тус талбайг өмнөх судлаачид цул сульфидын хүдэржилттэй гэж дүгнэсэн байдаг. Алтанширээгийн талбайн геофизикийн соронзон хайгуулын ажлаар соронзон гажил бүхий сонирхол татахуйц хувирлын хэсэг тогтоогдсон юм.

I. УДИРТГАЛ

Алтанширээгийн талбай нь Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт орших ба УБ хотоос ЗУ 450 орчим км-т, Сайншанд хотоос ЗХ 150 орчим км-т байрладаг. Хайгуулын талбайд 1940-1941 онуудад И.Е.Туришев, Ю.С.Желубовский нар ерөнхий эрлийн ажил, 1953 онд О.Т.Литенко төмрийн хүдрийн эрэл шалгалтын ажил, 1986-1990 онуудад Г.Бөмбөрөө нарын судлаачид 1:200000 масштабтай геологийн зураглалын ажил, 1992 онд П.Ганбаатар нар 1:50000 масштабын геологийн зураглалын ажлыг тус тус явуулсан.

Дээрх судалгааны ажлуудаас харахад уг районд агуулга, нөөц багатай төмрийн хүдрийн биетүүд байдаг бөгөөд энэ биетүүд нь неопротерозойн вулканоген тунамал хурдастай холбоотой колчеданы төрлийн хүдэржилт байх боломжтой гэсэн санааг дэвшүүлсэн байдаг.

II. ҮНДСЭН ХЭСЭГ

Соронзон хайгуулын аргачлал нь хурдас, чулуулгийн геологийн тогтоц, хүдрийн биетийн соронзон шинжээс хамаарсан дэлхийн соронзон орны өөрчлөлтийг судлах зорилготой хайгуулын геофизикийн нэг төрөл юм.

Ашигт малтмалын эрэл, хайгуулын үед соронзон хайгуулын аргачлалыг хэрэглэхэд төмрийн хүдрийн ордуудад шууд үр дүн үзүүлдэг онцлогтой. Үүний зэрэгцээ полиметаллын, сульфидын, зэс-никелийн төрлийн ашигт малтмалын хайгуулын үед хүдэр агуулагч чулуулаг, структурыг тодорхойлох зорилгоор хэрэглэдэг. Мөн хүдрийн хуримтлалаас гадна ашигт малтмал бүрэлдэх нөхцөл бүхий өөрчлөлт-хувирлын бүс, шилжилт, хагарлууд гэх мэт хүдэр агуулагч болон хүдэр хянагч бүсийг тодорхойлоход ач холбогдолтой.

III. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааны талбайд Канадын “SCINTREX” фирмийн ENVI Pro маркийн протоны магнетометрийг хэрэглэсэн бөгөөд тус магнетометрийн хэмжилтийн нарийвчлал

$\pm 0,1 \text{ нТ}$, 15000-120000 нТ-ийн хүрээнд соронзон орны бүтэн векторын утгыг бүртгэх чадвартай ба 32 Mbyte-ийн 1465623-5371953 цэгийн хэмжилт хийх дотоод санах ой, $\pm 1,5 \text{ м}$ -ийн нарийвчлалтай GPS бүхий төхөөрөмж юм.

Геофизикийн соронзон зураглалын ажлыг 1:20000 масштабаар хойноос урагш 1800 азимутын чиглэлд, хувирлын хэсэг дэх, нарийвчлан соронзон зураглал явуулсан талбайд 1:2500 масштабаар мөн чиглэлд, өндөр соронзон гажлын хэсгийг зүүнээс баруун чиглэлд 1:10000 масштабаар явуулсан. Тус талбайд уртрагийн дагуу болон өргөргийн дагуух хэмжилтийн цэгүүдийн байршлыг UTM WGS-84 системийн 49N зонд ENVI Pro магнетометрийн GPS-ээр тогтоосон бөгөөд талбайд хоногийн хувьслын өөрчлөлтийг 20 секундын завсарлагатай бүртгэж, талбайн хэмжилтийг 3сек буюу 5-15м-ийн давтамжтайгаар хэмжсэн ба талбайн соронзон орны бүтэн байгуулагчийн зургийг Geosoft Oasis Montaj 7.1.1 программ хангамж ашиглан зохиосон.

Геологийн доорх даалгаварууд өгөгдсөн;

1. Хүдэр агуулагч болон хянагч структурын тархалт, чиглэлийг ялгаж, физик утгын ангилал хийх

2. Тэдгээрийн хурдас хуримтлалтай холбоотой агуулагч формацийн орон зайн байршлыг тодорхойлох, боломжтой структур, хагарал, шилжилтүүдийн чиглэлийг талбайн түвшинд зураглах

3. Талбайн ерөнхий структур, регионал болон локал хагарлууд, тэдгээрийн хоорондын шилжээс зэргийг тодорхойлох

4. Соронзон орны утгаар ялгасан мужуудыг, хагарал, шилжилт болон хэвтээ чиглэлийн структурын дагуу гажлын харьцуулалт хийх.

IV. ҮР ДҮН

Талбайн соронзон зураглалын ажлын үр дүнд хээрийн хэмжилтийн үр дүнг боловсруулж, хагарлуудыг системчлэн, гажлуудын үүсгэгчийг ялгасан. Соронзон орны

*Electronic address: naranerdene.natsagdorj@yahoo.com

үр дүнгийн зургуудаас судалгааны талбайд тархсан хурдас, чулуулгийн хэлбэр, хэмжээ, тэдгээрээс үүсгэгдсэн гажлуудыг ангилан үндсэн тайлалт хийсэн.

Талбайн өмнөд хагаст орших улаанаас тод ягаан өнгийн хүрээнд илэрхийлэгдсэн харьцангуй өндөр гажлын мужуудад илэрхийлэгдсэн физик утгын градиент өөрчлөлт нь боржингийн биетүүд, боржиндиорит, боржинсиенитээс бүрдэх палеозойн интрузив бүрдэл, тэдгээрийн фазуудыг тусгаарласан тектоник хагарлуудтай холбоотой ажээ. Соронзон гажлын зурагт интрузив биетийн цухуйц болон бага гүнд орших хэсэг нь физик орны өндөр утгаар илэрхийлэгдсэн (57900-59000нТ) бол харьцангуй гүнд орших далдлагдсан хэсэг нь түүнээс арай бага утгаар (56800-58000нТ) тодорхойлогдоно -(Зураг 2, 3). Тус зурагт хагарлууд нь БХ-оос ЗУ, бараг уртрагийн дагуу чиглэлтэй хагарлыг хянасан ЗХ чиглэлийн хагарлууд гэсэн тогтолцоо ажиглагдсан.

Мөн өмнөх судалгааны геологийн зурагт тэмдэглэгдсэн байдаг адил эрэмбийн хагарлууд тус зураг дээр тусгалаа олсон байдаг. Түүнээс гадна талбайн ЗХ хагаст тодорхойлсон БУ-аас ЗХ чиглэлтэй шугаман хагарлаар протерозойн гнейс, кварцийн талст занар хянагдсан байна (Зураг 1, 2, 3). Нийт талбайн үнэмлэхүй соронзон гажлын эрчимжилтийн хүрээ 56874.9→60897.8нТ (дундаж утга=58010.7нТ). Стандарт хазайлт 150.4нТ байв.

Соронзон гажлын зурагт дээр өгүүлсэн гажлын үүсгэгчдийн өнгөний тодорхойлолт өргөн хүрээнд өөрчлөгдөж хөхөөс тод ягаан өнгөтэй болсон нь физик утгын ялгааг тодруулан харуулжээ. Хагарлын систем, структурын хувьд судалгааны талбайд тархсан хурдас, чулуулаг ерөнхийдөө нэгэн төрлийн, үүссэн цаг хугацаа, найрлагын хувьд ойролцоо учир соронзон гажлын зургаас ихэнх хагарал, структурыг тодорхойлсон болно.

Эдгээр нь эрэмбийн хувьд:

- БХ-оос ЗУ чиглэлтэй өөр хоорондоо хянагдсан 2 төрлийн хагарлууд
- Тэдгээрийг шилжүүлсэн БУ-аас ЗХ чиглэлтэй хагарлууд
- Талбайн төвд хувирлын бүсийг хянах хэвтээ нуман хагарал
- Эдгээрийг хянадаг өргөрөгийн дагуу чиглэлтэй залуу хагарлууд

Талбайн БХ хагаст, 1км гаруй диаметртэй дугуй хэлбэрийн өндөр гажлын биет, талбайн төвийн ЗХ хэсэгт төвтэй 1км х 3км

хэмжээтэй өндөр гажлын биетүүд нь харьцангуй болон үнэмлэхүй соронзон гажлын өндөр утгын мужид илэрхийлэгдсэн байсныг газар дээр нь шалгаж цэрдийн хурдсаар хучигдсан D2-ийн базальтаас үүсгэгдсэн болохыг тогтоолоо (Зураг 1, 2, 3, 4).

Эдгээр нь БХ-оос ЗУ болон өргөрөгийн дагуух хагарлуудаар зүсэгдсэн байдаг. Нийт талбайн харьцангуй соронзон гажлын эрчимжилтийн хүрээ -1146.2→2917.4нТ (дундаж утга = 885.6нТ). Стандарт хазайлт 144.9нТ. Талбайн баруун хагаст үнэмлэхүй соронзон гажлын 55842.48-60620.76нТ, харьцангуй соронзон гажлын -2073.25→2339.8нТ утгаар илэрхийлэгдэх хөхөөс тод ягаан өнгийн хүрээнд зураглагдсан нуман хэлбэртэй соронзон гажлын муж нь цэрдийн хурдсаар хучигдсан нүх сүвэрхэг базальтын гадаргад үзүүлэх соронзон орны нөлөөг харуулжээ (Зураг 2, 3).

Гажлын мужийн нуман хэлбэрийн дотор талд зураглагдсан нам утгын шалтгаан нь D2-ийн боржингийн түрэлтээс үүсгэгдсэн хил заагийн хувирлын бүстэй холбоотой байна. Мөн ул суурийн конгломератын дээр орших кварцитын найрлагаас хамааран энэхүү гажлын дүр төрх илэрхийлэгдэнэ.

Соронзон орны хэмжилтийн анхдагч боловсруулалтын үр дүнгээс өмнөх геологийн судалгааны ажлаар тэмдэглэсэн төмрийн болон полиметаллын илрэлийг судалгааны талбайн хойд хагаст орших дундаж гажлын утгаар илэрхийлэв (Зураг 2, 3). Гажлын утгын өргөн хүрээний өөрчлөлт нь протерозойн насны боржингийн жижиг шток, гематит, кварц бүхий төмөр малгай, кварц-серицит бүхий метаморф, мөн төмөрлөг кварцит, кристал занар зэрэг үүсгэгчээс хамаарсан байна.

Ерөнхийдөө тус гажлын үүсгэгчид болох протерозойн хурдсууд нь үнэмлэхүй ба харьцангуй соронзон гажлын дундаж утгаар илэрхийлэгдсэн ажээ. Гэхдээ энэ нь мөн далдлагдсан байдал, гадаргад харагдах гаршийн онцлогоос хамаарна гэж үзэж болохоор байгаа юм (Зураг 5, 6).

Нарийвчилан ялгаж хайгуул хийсэн талбай нь ерөнхийдөө маш сайн судлагдсан бөгөөд илрэлийн орчимд 1:2000 масштабын зураг хийж, бш хайгуулын өрөмдлөг, 21ш уулын малталтын ажил гүйцэтгэсэн байна. Тус ажлын үр дүнгээр полиметаллын найрлага байхгүй, бага зэргийн зэс агуулсан, 65-85%-ийн пиритийн агуулга бүхий сульфидын хүдэржилт тогтоогдсон ажээ. Хэвтээ чиглэлтэй хагарлаар хянагдах хүдрийн биетийн дундаж зузаан 8.7м,

хамгийн ихдээ 16.7м байна гэж тэмдэглэгдсэн. Хэвтээ чиглэлийн хагарал нь өргөрөгийн дагуу чиглэлтэй залуу хагарлаар хязгаарлагдах бөгөөд ялгасан талбайн хэмжээнд соронзон орны өндөр утгын гажлууд зураглагдаагүй нь тус хагарлын хавтгайгаас доош орших гүнд сонирхол татахуйц ямар нэгэн үүсгэгч байхгүйг нотолж байгаа юм.

V. ДҮГНЭЛТ

Алтанширээгийн талбайн хэмжээнд хийсэн талбайн соронзон зураглалын ажлын үр дүнд дараах дүгнэлтийг хийж байна.

Талбайн зураглалын эхний үр дүнгээс нарийвчлан тодруулах шаардлагатай гажлууд тогтоогдсон бөгөөд өндөр гажлын болон төмрийн илрэл орчимд 1:2500, 1:10000 масштабаар 2 жижиг талбайд хийсэн ажлын үр дүнг доор тайлбарлав.

1. Өндөр соронзон эрчимжилт бүхий баруун талбайн геологийн тогтоц нь мезозойн тунамал терриген, андезит базальтын найрлагатай хурдсаар хучигдсан дунд девоны нүх сүвэрхэг базальт бүхий суурьлаг найрлагатай чулуулгаас бүрджээ.

Соронзон орны өндөр утгаар илэрхийлэгдсэн, нуман хэлбэртэй гажил нь дээрхтэй холбоотой учраас өндөр утгатай байх тусам гадаргад ойр орших цухуйц, өргөгдөлтэй холбоотой байх нь гарцаагүй юм. Талбайд хийсэн шалгах маршрутын ажлаар тус

базальтыг ул суурийн болон том ширхэгт конгломерат хучсан байгааг тогтоосон.

Гажлын зүүн талд орших адил хэлбэртэй, нам утгын гажил нь боржингийн хил заагийг харуулсан байна.


Тус талбайд илэрсэн өндөр гажлын муж нь цаашдын судалгааны сонирхол татахуйц бус бөгөөд хайгуулын ажил хийх шаардлагагүй юм.

2. Талбайд тархсан хурдас, чулуулгууд маш их хувиралд автсан боловч төмрийн хүдрийн хувьд анхаарал татахуйц физик утга үзүүлдэггүй. Энэ нь гадаргад ойр, бага гүнд орших үлдэгдэл хүдэржилттэй буюу гажлын үүсгэгч нь исэлдлийн ч юмуу пиритээр баяжсан массив сульфидын эрдсүүдтэй холбоотой бололтой.


Соронзон зураглалын үр дүнд талбайн хэмжээнд ЗУ чиглэлийн сонирхолтой нуман структур тогтоогдсон. Харамсалтай нь энэхүү хэвтээ хагарлаар гүндээ хязгаарлагдсан хүдрийн биет нь хэмжээний хувьд цаашдын сонирхол татахааргүй байна. Өмнө өрөмдсөн өрөмдлөгийн үр дүнд энэ нь хамгийн ихдээ 16.7м зузаантай тэмдэглэгджээ. Хагарлын доор орших бага хэмжээний боржингийн шток нь үнэмлэхүй соронзон гажлын зурагт 57900-58200nT утгаар илэрхийлэгдсэн байна.

Тус шток нь 150м х 180м хэмжээтэй бөгөөд алтны хүдэржилттэй холбоотой байж болох юм.


-
- [1] П.Дугараа, Монгол орны геологи, ашигт малтмалын судалгааны геофизик, (2012)
 - [2] Г. Бөмбөрөө нар, 1:200000 масштабын геологийн зураглалын ажлын тайлан, (1990)




Зураг 1. Геологийн зураг




Зураг 2. Соронзон орны бүтэн байгуулагчийн зураг




Зураг 3. Үнэмлэхүй соронзон гажлын зураг



Зураг 4. Сансрын зураг



Зураг 5. Нарийвчлан соронзон зураглал хийсэн талбай



Зураг 6. Хувирлын бүс дэх геологийн зүсэл

Физик Сургалтын 3D Тооцоо-Дүрслэлт Лаборатори

П.Энхцэцэг¹, Т.Уламбаяр², О.Лхагва³, Б.Алтанхүү³

¹ХААИС-ийн Инженер технологийн сургууль, Хэрэглээний математик машин судлалын тэнхим,

²МУБИС-ийн Математик, Байгалийн ухааны сургууль, Мэдээлэл зүйн тэнхим,

³МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль, Физикийн тэнхим, Физикч,

Өнгөрсөн зуунд хөгжсөн хумхи ертөнцийн квант физикийн онол, туршлага, тооцооллын арга нь эдүгэ математик, мэдээллийн технологи, цацраг, бөөмсийн үүсгүүр, дүүгүүрийн цацраг урсгалын техниктэй хүч хавсраад байгалийн амьтай, амьгүй юмсын бүтэц зүйг бүр квант төвшнөөс нь төлжүүлэн бүтээсэн тооцоо-дүрслэлт туршилтаар судалдаг боллоо. Биологи, хими, физикийн шинжилгээний арга хумхи ертөнцөд ингэж нэгэн амьд нийлэв. Энэ гайхамшигт дэвшлийн үзэл санаа, аргыг дунд сургуулийн тооцоо дүрслэлт 2D болон 3D загвар лаборатор бүтээхэд дэлхий даяар өргөн хэрэглэх болов.

Өнөөдөр дэлхийн тулгуур шинжилгээний том, том төвд их үнэ өртөг бүхий техник, технологи шаардсан физик- хими- биологийн туршилтаас урьтал болгож, үзэгдэл- хувирлын математик загварыг тооцоо-дүрслэлээр амилуулаад тооцоо-туршилт явуулдаг болов. Гагцхүү тооцоот туршилтаар үнэ цэнэтэй шинэ мэдээ сэлт илэрэхүүд түүнийг даруй нотлохоор нүсэр мөнгө зарцуулан техник технологийн туршилтыг санхүүжүүлдэг болжээ. Математик загварчлал, тооцоо дүрслэлт туршилт үйлдвэрлэлийн бүхий л салбарт ингэж эрч хүч авснаар нь нийхэмийн хөгжлийг дэлбэрэлт рүү хөтлөх болов. Энэ өгүүлэлд физикийн 3D тооцоо-дүрслэлт загвар лаборатор бүтээх шинжилгээ, зохион бүтээх ажлын үр дүнгээс толилуулж байна. Энэхүү тооцоо-дүрслэлт 3D лабораторыг нэвтрүүлснээр суралцагсад физикийн тулгуур хуулийг Кулон, Ом, Фарадей, Планкийн адил туршилтаас ургуулан нээхийн хамт мэдээллийн технологийн их тэсрэлтийн хүч, чадлыг эзэмших тэмүүлэлд хөтлөгдөх болно.

Түлхүүр үг - мэдээллийн технологи, тооцоот туршилт, загвар лаборатори, компьютер загвар, физик сургалт

I. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Физик сургалтанд нэвтрүүлэх 3D загвар лаборатори бүтээх.

II. ЛАБОРАТОР БҮТЭЭХҮЙН ЭХ, ГАРЦ

Компьютер загвар. Онолын физик бол байгалийн үзэгдлийг математикаар загварчлан судлаад, хуулийг нь нээгээд, томъёог нь гаргадаг эрдэм. Улсын их сургуулиудын эрдэмтэн багш нарын баг ЕБС-ийн физикийн агуулга дахь тулгуур хуулийг “нээдэг” тооцоо-дүрслэлт загвар лаборатори зохион бүтээгээд байна. Эхний 2D лабораторыг нь БСШУЯ-ны Сайдын 2004 оны 41 тоот тушаалаар дунд сургуулийн сургалтад нэвтрүүлэх ажил эхэлсэн юм. 3D лабораторийг бүтээгээд байна. Хэд хэдэн аймагт сургалт явууллаа.

Хэрэгжих арга зүй. Анхан шатны сургалтанд бол эл лабораторийг хөдөлгөөнт үзүүлэн байдлаар ашиглаж болно. Ахлах ангид сурагчид физик үзэгдэл, хуулийг “нээх” зорилго тавьж тооцоо-дүрслэлт туршилт үйлдээд хэмжилтийн дүнг “KAMTASIA” програмаар хөдөлгөөнт мэдээлэлд хувиргана. Дараа нь туршилтын эл ший-зураг баримтыг тойруулан ухааныг уралдуулан ном хаялцах замаар асуудлын шийд рүү хамтаар тэмүүлнэ. Ургуулан сэдэж сэтгэх амин үйлийг өрнүүлэн мэтгэсээр шийдэлд хүрээд сурагчид тулгуур

хуулийг өөрснөө “нээгээд”, математик томъёог гаргана. Тооцоо-дүрслэлт туршилтыг үйлдэх, утга тайллыг хийхэд багш эрдмийн удирдагчийн өндөрлөгт байж сурагчдыг “хол” төөрүүлэхгүй чиглүүлэхийг чанд эрхэмлэнэ.

III. ФИЗИК СУРГАЛТ БА МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

Загвар лабортори физикийн хичээлийг мэдээлээс чөлөөлж суралцагсдын сэтгэлгээний хэрэглүүрт хувиргаж байгаа юм].

Мэдээллийн технологи нь хүн төрөлхтний хөгжлийн нэг гол хөтлөгч хүч болон хувирлаа. Энэ дэвшлийн сүнс нь математик загварчлалд суурилж, юмс, үзэгдлийг биежилд хувиргаад физик үйл хувирлыг мэдээллийн технолгоор амилуулан өргүүлнэ.

Математик, мэдээллийн технологи хийгээд техник технологийн дэвшлийг хувисал,, тооцоо дүрслэлт туршилт үйлдүүлэн байж, өсвөр үеийнхний бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх бодит хэрэглүүрт хувиргасанд эл бүтээлийн онцгой ач тус оршино. Ингэснээр физикийн хичээл дээр самбарт учир битүүлэг томъёо бичиж, хууль мэдээллийг сонсгодог доголдлоос ангижирна.

Физик дэх мэдээллийн технологийн гол судас нь физикийн 3D загвар лаборатори бүтээх ажил юм. Суралцагсад өөрснөө тооцоо дүрслэл лабораторын хэмжилт үйлдээд, баримтыг шүүн ном хаялцаж, ургуулан дүрсэлж бодсноор

*Electronic address: enkhsetseg_p@yahoo.com


тулгуур хуулиудыг нээж байгаа нь аливааг гүн төнхөж сэтгэх, багаар сэтгэж, бүтээх чадварыг хөгжүүлэх эх ундрага нь болно.

IV. ЗАГВАР ЛАБОРАТОРИЙН БАГЦ

3D загвар лабораторийг хот хөдөөгийн хэд хэдэн сургуульд туршсан. Тулгуур хуулиуд болон чухал хэрэглээтэй уялдсан 8 бүлэг, 66 лабораторийн ажилтай. Үүнд: вектор, векторын үйлдэл-4, механик-11, таталцлын орон-9, молекул-11, цахилгаан-14, соронзон-3, оптик-9, атом-5 ажлаас бүрдэнэ.

Зарим тооцоо-дүрслэлт туршилт

Ньютоны хуулийн тооцоот лаборатори



Зураг-1. Ньютоны хуулийг нээх загвар лаборатори

Хэмжилт-1. m масстай биед өөр өөр хүчээр үйлчлэхэд хөдөлгөөний хурдатгалыг хэмжинэ. ХЭМЖИЛТ-1

№	$F(H)$	$m(кг)$	$a(м/с^2)$
1	0.92	2.5	0.38
2	0.76		0.30
3	0.64		0.26

Сурагчид: хурдатгал хүчтэй шууд хамааралтайг тогтооно:

$$a \sim F$$

Хэмжилт-2. Хүч тогтмол байхад массыг өөрчилж хурдатгалыг хэмжнэ.

ХЭМЖИЛТ-2.

№	$m(кг)$	$F(H)$	$a(м/с^2)$
1	2.0	0.5	0.25
2	1.5		0.33
3	1.0		0.50

Сурагчид: Хурдатгал нь масст урвуу хамааралтайг илрүүлнэ.

$$a \sim \frac{1}{m} \quad (1)$$

Нэгтгэн сэтгэх: $a \sim \frac{F}{m}$. Болхыг сурагчид

мэдэрнэ.

Хууль: Пропорционалийн коэффициентээр тэнцүүлбэл:

$$F = kma \quad (2)$$


Тооцоо: Тоон баримтаас k -г олбол:

$$k = \frac{F}{ma} = \frac{0.92H}{0.38м/с^2 \cdot 2.5кг} \cong 1$$

Шинжилгээний дүгнэлт: Ньютоны 2-р хууль

$$F = ma \quad (3)$$

Хийн хуулийн тооцоот лаборатори



Зураг-2. Идеал хийг судлах загвар лаборатори

ХЭМЖИЛТ -3.

№	Процесс	$P(кПа)$	$T(K)$	$V(л)$	$\nu(моль)$
1	Изотерм	31,91	293,15	76,40	1
2		59,61		40,90	1
3		150,5		32,40	2
4		84,22		57,90	2
5	Изобар	101,42	312,75	25,65	1
6			411,15	33,72	1
7		202,84	334,35	27,42	2
8			424,35	34,70	2
9	Изохор	113,00	304,35	22,4	1
10		145,08	390,75		1
11		252,74	340,35		2
12		303,53	408,75		2

Сурагчид:

Хэмжилтээс изотерм процесс

$$PV = const \quad (4)$$

Изобар процесс

$$\frac{V}{T} = const \quad (5)$$

Изохор процесс

$$\frac{P}{T} = \text{const} \quad (6)$$

Нэгтгэн сэтгэх:

$$\frac{PV}{T} = \text{const} \quad (7)$$

Пропорционалийн коэффициентоор тэнцүүлбэл:

$$PV = RT \quad (8)$$

Хэмжилт-3-аас R -г олбол:


$$R = \frac{PV}{T} = 8.31 \frac{\text{Ж}}{\text{моль} \cdot \text{К}} \quad (9)$$

Үүнийг хийн түгээмэл тогтмол гэнэ. Нэг моль хийн хувьд $PV = RT$. V моль хийн хувьд

$$PV = \nu RT \quad (10)$$

Менделеев-Клапейроны тэгшитгэл гэнэ.

Кулоны хуулийн тооцоот лаборатори



Зураг-3. Кулоны хуулийг нээх загвар лаборатори

Хэмжилт-4: Цэнэгийн хэмжээг өөрчлөн туршуул цэнэгт үйлчлэх хүчийг хэмжинэ.

ХЭМЖИЛТ-4.

№	r (м)	q_1 (нКл)	q_2 (нКл)	F (нН)
1	1.5	0.6	1.0	2.38
2		1.0		3.96
3		1.6		6.34

Сурагчид: Хүч цэнэгийн үржвэрт шууд хамааралтай

$$F \sim q_1 q_2 \quad (11)$$

Хэмжилт-5: цэнэгүүдийн хоорондох зайг өөрчилбөл:

ХЭМЖИЛТ-5.

№	q_1	r (м)	q_2	F
---	-------	---------	-------	-----

	(нКл)		(нКл)	(нН)
1	1.4	1.12	1.0	9.86
2		1.59		4.97
3		2.1		3.09

Сурагчид: хүч нь зайд урвуу хамааралтай. Зэрэг нь тодорхойгүй

$$F \sim \frac{1}{r^n} \quad (12)$$

Шинжилгээ.

$$F \sim \frac{q_1 q_2}{r^n} \quad (13)$$

учир пропорционалийн коэффициент оруулбал

$$F = k \frac{q_1 q_2}{r^n} \quad (13)$$

Хэмжилт-2-оос ижил цэнэгтэй хоёр өөр зайд хүчний харьцаа бичвэл:

$$F_1 = k \frac{q_1 q_2}{r_1^n} \quad F_2 = k \frac{q_1 q_2}{r_2^n} \quad \frac{F_1}{F_2} = \frac{r_2^n}{r_1^n}$$

$$\frac{F_1}{F_2} = \left(\frac{r_2}{r_1} \right)^n \quad n = \frac{\ln\left(\frac{F_1}{F_2}\right)}{\ln\left(\frac{r_2}{r_1}\right)} \quad n \approx 2 \quad (14)$$


$$F = k \frac{q_1 q_2}{r^2} \quad (15)$$

к-г олж.

$$F = k \frac{q_1 q_2}{r^2} \Rightarrow k = \frac{F \cdot r^2}{q_1 q_2} \quad (16)$$

$k = 8.996 \cdot 10^9 \text{ Н} \cdot \text{м}^2 / \text{Кл}^2$. Үүнийг Кулоны тогтмол гэнэ.

Атомын цацаргалт



Зураг-4. Атомын цацаргалтыг судлах загвар лаборатори.

Хэмжилт-6. Дээд орбитуудаас нэгдүгээр түвшин рүү шилжих шилжилтийн давтамж, энерги, долгионы урт, амьдрах нас, төлөвийн радиусуудыг хэмжинэ.

ХЭМЖИЛТ-6.

№	m	n	$E(\text{эВ})$	$\tau(10^{-8} \text{ c})$	$\nu(10^{15} \text{ Гц})$	$\lambda(\text{нм})$
1	1	2	-3,4	0,2128	2,469	121,5
2		3	-1,5	0,1793	2,927	102,5
3		4	-0,85	0,7825	3,085	97,24
4		5	0,54	0,2424	3,160	94,93

Хэмжилт-6 боловсруулалт:

$$E_n = \frac{E_1}{n^2} \quad (17)$$

$E_1 = -13.6$ үндсэн төлөвийн энерги 1886 онд Бальмер хэмжсэн.

$$\text{Радиусуудын харьцаа} \quad \frac{r_n}{r_1} = n^2 \quad (18)$$

n квант төлөв дэхь электроны хурд

$$v_n = \frac{v_1}{n} \quad (19)$$

2 ба 3-аас тухайн орбит дахь

$$v_n \cdot r_n \sim n \quad (19)$$

n квант төлөвийн тойрог орбит дахь электроны дүүгүүр момент

$$m \cdot [\vec{v}_n \cdot \vec{r}_n] = \vec{L}_n \quad (20)$$

Тойрог орбитод $\vec{r}_n$, $\vec{v}_n$ перпендукуляр учир

$$m \cdot r_n \cdot v_n = L_n \quad (21)$$

$$v_n = \frac{v_1}{n} \text{ гэдгээс } L_n \sim n \text{ буюу } L_n = n \cdot H$$

$$H = \frac{L_n}{n} = 1.061 \cdot 10^{-34} \text{ Ж} \cdot c = \frac{h}{2\pi} = \hbar \quad (22)$$

Орбит дахь электроны дүүгүүр момент

$$m \cdot r_n \cdot v_n = L_n = n\hbar \quad (23)$$

V. ДҮГНЭЛТ

Физикийн 3D загвар лаборатрыг бүтээснээр ЕБС-д туршилтын техникт лабораторын зэргэцээ тооцоо дүрслэлт туршилт үйлдэх боломж бүрдэж байна.

Загвар лабораторийг ашиглан хичээл заах нь үлгэр, домог мэт сонсгож, томъёог тулган заадаг байдлаас ангижирч, суралцагсад тухайн үзэгдлийг мөн чанарыг нь ухан ойлгож, хууль дүрэм, томъёог өөрсдөө нээн илрүүлдэг тийм сургалтын аргыг бий болгоно.

Физик үзэгдлийн 3D загвар лабораторыг бүтээх явцдаа мэдээллийн технологи, компьютерграфикийн олон дэвшлийг шүүрдэн эзэмшээд эдүгэ webpage аргыг зохион бүтээх ажилдаа хэрэглэж эхлэв.

Бидний хуримтлуулсан туршлагыг ЕБС-ийн багш бэлтгэх сургалтад ямар нэг байдлаар нэвтрүүлбэл ач тустай болно гэж үзэж байна.

- [1] O.Lhagva, T.Ulambayar, P.Enkhtsetseg, "Virtual Laboratory for Physics Teaching" International Conference on Management and Education Innovation, Kuala Lumpur, Malaysia, 319, (2012)
- [2] Edward Angel "Interactive Computer Graphics" A Top-Down Approach with OpenGL, Third Edition, (2004)
- [3] O Lhagva, Kh. Tsookhuu, L. Erdenetuya et al. Use of a Physics Laboratory Model Pilot for Physics and Distance Learning. International Conference on Future of Open and Distance Learning in Mongolia, Sponsored by UNESCO, 2-4, Nov. 2005. Ulaanbaatar, Mongolia, 174, (2005)
- [4] О.Лхагва, Б.Алтанхүү, Т.Уламбаяр, Х.Отгонмөнх "Информационный и коммуникационной технологии в Общее образование" 2007 г. Кыргызстан Иссык-Куль, Азиатский Банк развития.

- [5] Физикийн 3D загвар лаборатори CD 2013, 2014, 2015 он.

ГАРЧИГ

1. **Spectroscopy with Polarization Controlled Entangled Photons for Detecting Orbital Excitation in Solids**
P.Munkhbaatar, D.Ulam-Orgikh, and J.Vanchinkhuu.....1-6
2. **Generation and Detection of Squeezed Phonon**
P.Munkhbaatar7-10
3. **Study of Gamma Ray Induced Paramagnetic Defects in SiO₂**
N.Tuvjargal, D.Baatarkhuu, T.Ochirkhuyag, J.Davaasambuу, and G.Shilagardi.....11-16
4. **Хөө, Үнсэнд Хийсэн Рентген Дифракцийн Фазын Судалгаа**
Ж.Ванчинхүү, Э.Баянжаргал, Ж.Даваасамбуу.....17-22
5. **Цахилгаан Шүүлтүүр Дотор Явагдах Титэмт Ниргэлгийн Хязгаарын Параметруудийг Тооцоолох нь**
Ж.Ванчинхүү, П.Мөнхбаатар, Б.Бат-эрдэнэ, Ш.Мөнхжаргал.....23-28
6. **Вакуумные Технологии Получения Материалов, Содержащих Углеродные Наночастицы Спектральное**
Э.М.Шпилевский, П.Тувшинтур, Г.Шилагарди, С.А.Филатов.....29-32
7. **Свойства Фуллерен Содержащих Материалов-Новые Возможности для Сенсоров**
Э.М.Шпилевский, П.Тувшинтур, Г.Шилагарди, С.А.Филатов, А.Г.Солдатов...33-34
8. **ANSYS Программын Шилжилтийн Горимын Динамик Аргачлалаар Пуужингийн Хатуу Түлшний Хөдөлгүүрийн Цэнэгийг Судалсан нь**
Ө. Батбаяр, Ли Жуо.....35-40
9. **Comparison of Air Pollution Measurement (Zuun Ail area)**
B.Bulgansaikhan, S.Lodoisamba, D.Shagjjamba, and G.Gerelmaa.....41-44
10. **Могодын Хагарлаас Үүсэх Газар Хөдлөлийн Аюулыг Магадлалын Аргаар Үнэлэх нь**
Т.Нарангарав, Ц.Баатарчулуун, Б.Ганбат.....45-48
11. **Алтан Ширээгийн Талбайн Геофизикийн Соронзон Хайгуулын Ажил**
Н.Наран-Эрдэнэ49-58
12. **Физик Сургалтын 3D Тооцоо-Дүрслэлт Лаборатори**
П.Энхцэцэг, Т.Уламбаяр, О.Лхагва, Б.Алтанхүү.....59-62

МУИС-ийн Эрдэм Шинжилгээний ФИЗИК сэтгүүлд өгүүлэл бичих журам

1. *Бичиглэлийн хэлбэр*
Цаасны хэмжээ A4 байна. Бичиглэл дээд талаасаа 0.845inch (2.15cm), доод талаасаа 0.845inch (2.15cm), зүүн талаасаа 0.845inch (2.15cm), баруун талаасаа 0.845inch (2.15cm) буюу хэвлэгдсэн материалын нийт өндөр 10 inch (25.4cm), өргөн 6.27 inch (15.93cm), (хамгийн ихдээ өндөр 25.5cm, өргөн 16cm-ээс хэтрэхгүй) байна.
2. *Хэл*
Өгүүллийг Англи, Монгол, Орос хэлний аль нэгээр **Latex, MS Word, Word perfect** программ ашиглан **Times New Roman** фонт ашиглан бичсэн байна.
3. *Өгүүллийн бүтэц*
Сэтгүүлд өгөх эрдэм шинжилгээний өгүүллийг дараах бүтцийг баримтлан бичнэ.
 - Гарчиг
 - Зохиогчдын нэр, байгууллага, хаяг
 - Товч утга /тавин үгнээс хэтрэхгүй/
 - Мэргэшлийн индекс
 - Түлхүүр үг (Заавал биш)
 - Удиртгал
 - Үндсэн хэсэг
 - Онолын үндэс
 - Хэмжилтийн арга зүй, хэмжилт гэх мэт
 - Үр дүн, дүгнэлт
 - Ишлэл буюу ном зүй
 - Товч утгын орчуулга
4. *Бичиглэл хийхэд баримтлах зарчмууд*
 - 4.1. Ишлэлийг дөрвөлжин хаалтанд [1], [7, 10-12.14] гэх мэт тэмдэглэнэ. American Physics Society (APS)-ийн Physics Review A (PRA) style хэрэглэнэ.
 - 4.2. Тооны аравт, зуутын таслалыг цэгээр тэмдэглэнэ.
 - 4.3. Томъёон дахь үсгийг заавал налуугаар бичнэ.
 - 4.4. Нэгж болон тусгай функцуудын нэрийг (sin, tg, log, exp, det, тгэх мэт) босоогоор бичнэ.
 - 4.5. Графикийг Enhanced PostScript (*.EPS) форматаар бэлтгэнэ. Графикт координатын тэнхлэг 1pt өргөнтэй байхаар бодож бусад шугамын өргөнийг сонгоно. Графикт тайлбарыг налуугаар (9pt) бичнэ.
5. *Бичиглэл хийх үсэгний хэв маяг*
 - 5.1. Header (хуудасны толгой)-9pt, *italic*, тэгш талын зүүн үзүүрт нь хуудасны дугаар, 0.5inch зай аваад зохиогчийн нэр, цэг тавиад гарчиг бичнэ. (хоёроос дээш зохиогчтэй бол .. нар гэж товчилно, гарчиг нь нэг мөрөнд багтахгүй бол гол утгыг нь гарган хураангуйлж багтаана)
 - 5.2. Гарчиг-14pt, Bold, Том үсгээр эхэлж жижиг үсгээр бичнэ
 - 5.3. Зохиогч-11pt, Bold, Томоор эхэлж жижгээр бичнэ
 - 5.4. Хаяг-9pt, *italic*.
 - 5.5. Abstract (Товч утга)-9pt, Үндсэн хэсгийн баруун, зүүн талаас 1 inch (2.54cm) зайтай бичнэ.
 - 5.6. Мэргэшлийн индекс- 11 pt (PACS number Physics and Astronomy Classification Scheme: <http://www.aip.org/pacs> хаягаас харна уу.
 - 5.7. Үндсэн хэсэг- 11pt, Зөвхөн хоёр баганаар (хоорондын зай нь 0.25inch=6.35mm)
 - 5.8. Бүлгийн (section) гарчиг- 11pt, ALL CAPITAL, Bold, дугаарлавал Ром тоо хэрэглэнэ.
 - 5.9. Дэд бүлгийн (subsection) гарчиг- 11pt, Томоор эхэлж жижгээр бичнэ, Bold, дугаарлавал A,B,C,... гэнэ.
 - 5.10. Ишлэл буюу ном зүй – 11pt.
6. *Өгүүллийг хүлээн авах:*
 - 6.1. Өгүүллийн тод хэвлэсэн хоёр хувийг файлын хамт авна. Зургийн файлыг тусад нь авна.
 - 6.2. Хэвлэсэн хувь дээр зохиогчид гарын үсэг зурсан байна.
 - 6.3. Өгүүлэл хэвлүүлэхийг зөвшөөрсөн эрдэм шинжилгээний семинарын эрхлэгчийн гарын үсэг бүхий зөвшөөрөлтэй байна.

(Өгүүллийг бичихдээ олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Америк физикийн нийгэмлэгийн сэтгүүлийн бичиглэл, тэмдэглэлийн журмыг ерөнхийд нь баримтална. <http://publish.aps.org/INFAUTH/msprep.html>)

Редакцийн зөвлөл